

Mongolian Economy

2022 оны 03 сар (182)

www.mongolianeconomy.mn

Бүтээн байгуулалт

Эрчээ алдсан эрчим хүчийг
сэргээх станц

Элчин сайд

Цай Вэньруй: Хятад-Монголын
эдийн засаг, худалдааны хамтын
ажиллагаанд саруул ирээдүй бий






ЭРДЭНЭС
ОЮУ ТОЛГОЙ


Өнгөрсөн онд “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийг тойрсон олон асуудлуудыг эерэгээр шийдэж, зорьсон зорилтууддаа хүрч ажилласан.

“Оюу толгой”-н далд уурхайн үйлдвэрлэлийн эхний шат буюу анхны тэсэлгээ хийгдэж үйлдвэрлэл эхэлсэнтэй холбоотойгоор ирэх жилүүдэд талууд хамтын ажиллагаагаа бататган, нэгдсэн нэг ойлголттойгоор урагшилж тогтвортой олборлолт болон төлөвлөсөн ажлууд цаг хугацаандаа хийгдэх нь чухал юм гэдгийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэрэнбат онцлов.

Мөн Монгол Улсын Засгийн газар, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх, Монгол улсын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд бүхий л талаар хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Тогтвортой олборлолт болон төлөвлөсөн
ажлууд цаг хугацаандаа хийгдэх нь чухал





SPEEDMASTER MOONWATCH
CO-AXIAL MASTER CHRONOMETER

LOOKS MAGICAL. WORKS BEAUTIFULLY.

Таны хүсэлд яг нийцэх цагийг бүтээх бидний мөрөөдөл биелэхэд тун ойртсон байна. OMEGA цагны калибр хөдөлгүүр бол хамгийн бяцхан эд ангиудын нэгээхэн ертөнц юм. Эдгээр нарийн ширхэгээс бүрдэх цагны эд ангиуд бүхлээрээ гайхалтай ажиллаж тамирчин төдийгүй далайн гүний шумбагчид, тэр байтугай сансрын нисгэгчдийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн өндөр нарийвчлалтай цагнуудыг бий болгоод байна.

Ω
OMEGA

OMEGA boutique
Shangri-La молл 1 давхарт 75057055



ӨСДӨГ
МАШИН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

100%

70%

30% бэлэн мөнгө

5-200 сая

ГЭРЭЭНИЙ ДҮН

5-200 сая

1%

ХҮҮ

1.5%

60 сар

ХУГАЦАА

60 сар

1%

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

1%

1%

ДААТГАЛ

1%

-Тээврийн хэрэгслийн даатгал (min-1.5%)

-Албан журмын даатгал (машины үзүүлэлтээс хамаарна)

-Хөрөнгө оруулалтаас суутгах
-Бэлэн мөнгөөр төлөх

-Бэлэн мөнгөөр төлөх

Өнөөдрөөс эхлэн таны машины
ҮНЭ ЦЭН УНАХ БИШ ӨСӨЖ ЭХЛЭХ БОЛНО

MONGOLIAN ECONOMY

11 ЖИЛ



МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР САР ТУТАМ

**Mongolian
Economy**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр (9999 4248)

РЕДАКТОР:
Н.Энхбаяр (9916 1303)

АНГЛИ РЕДАКТОР:
Роберт Йохан Шрайверс
Жаклин Истриж

СЭТГҮҮЛЧИД:
Г.Даваадорж
Г.Орхон
Т.Амаржаргал
Б.Шүрэнчимэг

ОРЧУУЛАГЧ:
М.Ариунзаяа

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
7011 5476, 7011 5477

ХАЯГ: Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг, I хороо,
Экспресс тауэр. 11 давхар #6

ВЭБ: www.mongolianeconomy.mn
И-МЭЙЛ:

info@mongolianeconomy.mn

FACEBOOK: Mongolian Economy

TWITTER: EconomyMongolia

УТАС: 7011 5476, 7011 5477

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/х-2762

СЭТГҮҮЛ ЗАХИАЛГА:

Монгол шуудан (Утас: 7007 8916)
Түгээмэл шуудан (Утас: 7011 5015)

**Mongolian
Economy**

2021 оны 11, 12 сар (178, 179)

www.mongolianeconomy.mn

Ярилцлага

Х.Батжаргал: Хөрөнгө оруулалтын
орчинд цогц шинэчлэл хэрэгтэй

Анхаарлын төвд

“Улайссан” койн, токениуд

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЧИНД ГЭРЭЛ
АСАХ УУ?

СЭТГҮҮЛ
ЗАХИАЛГА:
МОНГОЛ ШУУДАН
ТҮГЭЭМЭЛ ШУУДАН



Утас: 7011-5477, 7011-5476

www.mongolianeconomy.mn

Хөгжлийн банк 08

Хөгжилд хөтөлсөн ч болоосой

Инфографик 11

Монгол Улсын хөгжлийн банкны санхүүгийн үзүүлэлтүүд

Тогтвортой санхүүжилт 12

С.Мөнгөнчимэг: Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх санхүүжилтийн стратеги боловсруулж байна

Элчин сайд 16

Цай Вэньруй: Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд саруул ирээдүй бий

Фельетон 20

Хөрөнгө цаашаа Монгол

Дэд бүтэц 22

Гацаанаас гаргах ган замууд



Интернэт 24

Анхдагч байх амаргүй

Дижитал шилжилт 26

Шинэ цагийн цахим нүүдэлчид

Үзэл бодол 29

Бид яагаад бэлэн мөнгөөр төлбөр хийдэг вэ



Дэлхий 2022 онд 32

Цурманд орж буй

Дэлхий 2022 онд 33

Эргэж ирсэн, гэхдээ удахгүй

Дэлхий 2022 онд 35

Стримингийн дайн

Дэлхий 2022 онд 36

Шинэ загвар, шинэ сэргэлт, шинэ гүрэн

Дэлхий 2022 онд 37

Үйлдвэрлэгч улс болъё

Зочин 39

Д.Цэрэнбат: Монголынхоо төлөө өөрийн чадах хэмжээндээ зүгээр суухгүй байх бодол бий

Бүтээн байгуулалт 42

Эрчээ алдсан эрчим хүчийг сэргээх станц

Build Mongolia 44

Т.Баттулга: BUILD MONGOLIA-2022 бол бүтээн байгуулалтын салбаруудын хувьд нэг цэгийн төвлөрөл юм

Хөгжлийн банк

Хөгжилд хөтөлсөн ч болоосой



Ирэх онд
нийтдээ 800 сая
ам.долларын
эх үүсвэрийг
төлөх
шаардлагатай.

Хөгжлийн банкны нийт зээлийн активын 58.4 хувь буюу 1.88 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд шилжсэн нь цөөнгүй улс төрчийн үнэн төрхийг илчилж, Монголд засаглалын гажуудал хэр гүнзгийрснийг дахин нэг харуулав. Зарим нэгний хувьд Хөгжлийн банк дампуурах нь өлзийтэй санагдсан байж мэдэх. Учир нь тус банкныг татан буулгаснаар зээл нь Засгийн газарт шилжиж, чанаргүй зээлүүдийг шүүхээр шийдвэрлэхэд 4-6 жил зарцуулна. Энэ хугацаанд байдал хаашаа ч эргэж болно.

Арилжааны банкуудын хувьд чанаргүй зээлийн хэмжээ хэдхэн пунктээр нэмэгдэхэд үтэр түргэн арга хэмжээ авч, байдлыг залруулдаг. Мөн зээлийн эргэн төлөлт гурван сараар хэтрэхэд л чанаргүй зээлийн ангилалд шилжүүлдэг. Саяхан Монголын банкны холбооноос 2021 онд салбарын хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ 8.5 хувь болж, өмнөх оноос гурван пунктээр буурсан талаар мэдээлсэн. Гэтэл Хөгжлийн банк улс төрчдийг чимээгүй хөлжүүлж ирсний гороор 58.4 хувийн зээл нь чанаргүй ангилалд шилжээд байна. Энэ бол нэг жилээс илүү хугацаа хэтэрсэн

зээл гэдгийг сануулъя.

Хөгжлийн банкны асуудал ил болмогц тус банкны зарим зээлдэгч ханшийн савлагаанд дарлуулж, цар тахлын хөлд үрэгдсэнээ тоочиж байна. Гэхдээ цар тахал хэнийг ч ялгаагүй. Хэрэв үнэхээр аргагүйд хүрсэн бол зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулж болох байсан. Харин тэд тэгээгүй юм.

Үндсэн үүргээсээ ихээхэн гажиж, улсын хөгжлийг тэтгэхэд бус цөөн хэдэн хүн, хуулийн этгээдийг хөлжүүлэхэд нөлөөлсөн тус банкны эргэн тойронд юу болов.

Өрийн сүлжээ

Хөгжлийн банк бол Монгол Улсын хөгжилд шаардлагатай томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан институт. Энэ утгаараа Монголбанкнаас тогтмол шалгалт хийж, Засгийн газраас мөн хяналт тавьж ирсэн. Бусад улс оронд ч энэ төрлийн институт бий.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн “2017 онд Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн баталснаас хойш Төв банк тодорхой ▶

► хэмжээнд хяналт, шалгалт хийж ирсэн. Гэхдээ тун хязгаарлагдмал хүрээнд. Өдийг хүртэл яагаад нуусан юм бэ гэх шүүмжлэл олон нийтээс их ирж байна. Гэвч бид хуулийн хүрээнд гуравдагч этгээдэд хяналт, шалгалтын дүнг мэдээлэх эрхгүй байсан” гэсэн юм. Харин тус банкны тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн “Хөгжлийн банк валютын ханшийн зөрүүнд асар ихээр өртсөн. Ялангуяа “Самурай” бондоор иенийн санхүүжилт авсан нь маш их нөлөөлсөн” гэжээ.

"Самурай" бондыг манай улс 2013 оны арванхоёрдугаар сарын 30-ны өдөр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны баталгаатай гаргасан. Нийт 30 тэрбум иенийн дүн бүхий 10 жилийн хугацаатай тус бондын хүү харьцангуй бага буюу жилийн 1.52 хувь. Ирэх оны арванхоёрдугаар сард бид “Самурай” бондыг төлөх ёстой. Энэ нь ойролцоогоор 280 сая ам.доллартой тэнцэж байна.

Самурай бондоос ч гадна төлөх ёстой өр, зээлүүд бий. Түүх сөхье. Хөгжлийн банк 2011 онд байгуулагдсанаасаа хойш нийтдээ 6.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг Засгийн газрын баталгаатай болон баталгаагүй татан төвлөрүүлжээ. Өнөөдрийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 31 хувь нь Засгийн газрын баталгаатай эх үүсвэр байна. Эдгээр эх үүсвэрийг 2023 оны сүүлчээр төлж эхэлнэ. Тодруулбал, ирэх оны аравдугаар сард 1.7 их наяд төгрөгийн эргэн төлөлт хийнэ. Дараагаар нь Засгийн газрын баталгаатай "Самурай" бондын өрийг төлнө. Энэ мэтчилэн тооцвол нийтдээ 800 сая ам.долларын эх үүсвэрийг ирэх онд төлөх шаардлагатай.

Олон улсын гэрээ хэлцлийн дагуу өр, төлбөрөө төлөх нь гарцаагүй зүйл. Гэвч олон улсаас эх орныхоо нэрээр дэнчин тавьж босгосон санхүүжилт нь эрх мэдэлтнүүдийн гарын салаагаар урсаж, чанаргүй зээлийн ангилалд орчихлоо. “Чи зээлээ төлчихвөл, би зээлээ төлнө. Цаад хүн бас зээлээ төлнө” гэдэг өрийн сүлжээнд улс орон даяараа орчихсон нь хариуцлагагүйн илрэл. Гэхдээ үүнийг залруулах ёстой. Энэ хүрээнд Хөгжлийн банкны чанаргүй зээлийн мэдээллийг нэгдүгээр сарын 20-ны өдөр, зээлийн багцын мэдээллийг нэгдүгээр сарын 31-ний өдөр ил болгож, олон нийтэд мэдээлсэн. Ийнхүү сар шинийн босгон дээр Хөгжлийн банк тойрсон дуулиан газар авч, өнөөг хүртэл хаврын түймэр шиг авалцаж байна. Чанаргүй зээлийн мэдээлэл ил болсноос хойш 48 хоногийн хугацаанд буюу

гуравдугаар сарын 9-ний байдлаар 78.8 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлжээ. Эндээс мөнгөгүйдээ бус авснаа эргүүлж төлөх хүсэл байгаагүй нь харагдана.

Өөр нэг санаа зовоосон асуудал нь чанаргүй зээлийг 2023 оны аравдугаар сараас өмнө буюу өр төлбөрөө төлж эхлэхээс өмнө бүрэн барагдуулах уу гэдэг эргэлзээтэй. Хоёрдугаар сарын 27-ны байдлаар 52.4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 44 үйлчилгээний объект, 1.9 тэрбум төгрөгийн долоон үйлдвэр, 32 тэрбум төгрөгийн 46 орон сууц, 26.6 тэрбум төгрөгийн 82 газар, 2.3 тэрбум төгрөг дөрвөн зоорь, 656 сая төгрөгийн дуусаагүй гурван барилга, 228 сая төгрөгийн үнэлгээ бүхий долоон фермийн барилга, 564 сая төгрөгийн зургаан гарааш гээд нийт 195 ширхэг үл хөдлөхийн барилга, объектыг битүүмжилсэн байна. Барьцаа хөрөнгийн үнэлгээ тогтоох болон бусад хяналт, шалгалт үргэлжилсээр буй.

Сангийн сайд Б.Жавхлан "Хөгжлийн банканд "Самурай" бондын 30 тэрбум иенийн Засгийн газрын баталгаатай, кросс дефолт үүсдэг бонд бий. 2023 онд төлөгдөх ёстой. Энэ эх үүсвэрээр олгосон зээлүүд төлөгдөхгүй бол Засгийн газрын эх үүсвэрээр төлөх эрсдэлтэй. Тиймээс чанаргүй зээлтэй бүх боломжоороо тэмцэнэ" гэж мэдэгдсэн. Харин Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо Хөгжлийн банкнаас албан тушаалын давуу байдлаа ашиглан зээл авсан, зээлээ зориулалтын бусаар ашигласан, зээлээ эргэн төлөхгүй байгаа зээлдэгчдэд хариуцлага тооцохын тулд хууль, хяналтын байгууллагуудтай нягт хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн.

Ирээдүйн төөрөг

Хөгжлийн банкныг одоогоос 11 жилийн өмнө Монгол Улсын эдийн засаг дэлхий дахинаа цойлж, 17-18 хувьд хүрч байх үед байгуулсан. Тухайн үед өсөлтийг урт хугацаанд хадгалж, бэхжүүлэх зорилгоор УИХ, Засгийн газрын шийдвэрээр Хөгжлийн банкны тухай хуулийг баталж, тус банкныг байгуулсан түүхтэй. Банк байгуулагдсан эхний таван жилдээ 5.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг аж ахуйн нэгжүүдэд олгожээ. Улмаар 2016-2017 онд хууль, эрхзүйн томоохон шинэчлэлийн үр дүнд Монголбанкны шалгалтад тогтмол хамрагдах болсон. Харин 2017-2021 оны хооронд 2.4 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон гэсэн дүн мэдээ бий.

Өнгөрсөн онд Засгийн газрын шийдвэрээр ►

**Монголбанк
гуравдагч
этгээдэд
хяналт,
шалгалтын
дүнг мэдээлэх
эрхгүй байсан.**

Жилийн 5.5
хувийн хүүтэй
бондын мөнгийг
орлого олохгүй
зүйлд голдуу
үрсэн.

Хөгжлийн банкийг Эксим банк болгох, экспорт-импортыг дэмжих, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чиглэсэн санхүүжилт олгодог байхаар шийдвэрлэсэн. Ингээд шинэ чиг үүрэг, зорилгоо биелүүлэхэд санхүүгийн хувьд хэр бэлэн байгааг шалгахад өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Монголбанкнаас ээлжит шалгалт хийснээр асуудлын гогцоог илрүүлсэн гэдэг.

Хөгжлийн банкийг цаашид Эксим банкны зарчмаар ажиллуулснаар арилжааны банкуудтай өрсөлдөхгүй. Харин экспортыг өсгөхийн тулд бусад банкт хамтран хамтын санхүүжилт олгодог болох юм. Мөн мах, ноос, ноолуур гэх мэт экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд хаана нь ямар гацаа үүсэж буйг тодорхойлж, эдгээрийг шийдвэрлэх төслийг санхүүжүүлнэ. Үүнээс гадна “Импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн төслүүдийг дэмжинэ” гэж Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Н.Мандуул танилцуулж байв. Гэхдээ Хөгжлийн банк хэчнээн “зүсээ хувиргасан” ч улс төрчдийн нөлөө хэвээр байвал ямар ч сайхан лоозонтой төсөл замхарна. Түүгээр барахгүй эрх мэдлээ ашиглан өөртөө давуу байдал бий болгосон албан


тушаалтнуудтай хатуу хариуцлага тооцохгүй бол энэ байдал давтагдсаар байна гэдгийг эдийн засагчид сануулсан.

Эдийн засагч Ц.Лут-Очир “Хөгжлийн банкийг анх байгуулахад нь ажиллаж үзсэн. Улс төрчдийн оролцоо, мөнгөний төлөөх тэмцэл жинхэнэ оролцдог газар. Эхэндээ намын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх нэрийдлээр жилийн 5.5 хувийн хүүтэй бондын мөнгийг орлого олохгүй зүйлд их үрсэн. Сүүлдээ үйлдвэр, уурхай хөгжүүлнэ гээд улс төрчид шууд хуваарилж авдаг болсон. Зээлийн барьцаа нь ихэвчлэн ирээдүйн орлого. Дампуурах нь жам ёсны зүйл байсан” гэж шүүмжилсэн удаатай. Харин УИХ-ын гишүүн Т.Доржханд “Хөгжлийн банкнаас зээл авсан улс төрчид хэдийн мөнгө хүүлэлт, мөнгө угаалт хийчихсэн байгаа. Тиймээс энэ явдлыг давтахгүйн тулд улс төрийн карьерийг нь бүрэн хязгаарлах ёстой” гэсэн юм. Эндээс улс төрчид, эрх мэдэлтнүүд болон энгийн иргэдийн хооронд ямар том зааг ялгаа үүссэнийг харьцуулж болно. Иргэд зургаан хувийн хүүтэй ипотекийн зээлийг маш их хүлээлтийн дараа олж авдаг. Цар тахлын өмнө буюу 2019 оны арванхоёрдугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 96.1 хувь нь хэвийн, 2.0 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээлийн ангилалд орсон байна. Одоо ч ийм хэмжээнд буй.

Харин Хөгжлийн банкны зээлдэгчид үүнээс ч бага хүүтэй зээлд бүдрэв. Нийт зээлийн 58.4 хувь нь чанаргүй ангилалд орно гэдэг хэтэрхий хариуцлагагүй, халаглам байдал. Хэн нэгний боломжийг хулгайлан өөртөө давуу байдал олгочихоод ахин татвар төлөгчдийн нуруунд ачаа үүрүүлэхээс буцахгүй байна гэдэг дэндүү шударга бус. Эксим банк байгуулсан ч улс төрчдийн савраас ангид байлгахгүй л бол юу ч өөрчлөгдөхгүй. Хэдэн жилийн дараа Хөгжлийн банкны гунигт түүхийг Эксим банк давтах л болно.

Одоогоос хэдхэн жилийн өмнө Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас улс төрчид зээл авсан нь илчлэгдэж, нийгэм даяараа шуурч байсан. Өнөөдөр Монгол Улсын Хөгжлийн банкны талаар шүүн хэлэлцэж байна. Харин ирээдүйд бид юуны тухай ярих бол... Магадгүй “Эдийн засгийг сэргээх 10 их наядын хөтөлбөрийн санхүүжилт салхинд хийсчээ, салхин талд нь өнөө л улс төрчид байжээ” хэмээн халаглан суух вий. ■


Чанаргүй зээлийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк

Инфографик: Монгол Улсын хөгжлийн банкны санхүүгийн үзүүлэлтүүд


Актив хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк


Зээлийн багц /тэрбум төгрөг/ 2022 оны 3 сарын 9-ний байдлаар

■ Чанаргүй ■ Хэвийн ■ Анхаарал хандуулах




Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Өөрийн хөрөнгө /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Хөгжлийн банкны чанаргүй зээлийг харьцуулах нь




Эх сурвалж: 1212.mn, Сангийн яам, Хөгжлийн банк

Зээл ба урьдчилгаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Тогтвортой санхүүжилт

С.Мөнгөнчимэг: Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх санхүүжилтийн стратеги боловсруулж байна



Засгийн газраас дэвшүүлж буй хөгжлийн бодлогуудыг хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлэх, санхүүжилтээ оновчтой, зөв удирдах зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Монгол Улсыг тогтвортой хөгжилд хүргэхэд шаардлагатай санхүүжилтийг бий болгохын тулд Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратегийг боловсруулаад байна.

Энэхүү стратегийн хүрээнд гадаад, дотоод шинэ санхүүгийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх, одоо байгаа боломжит нөөцөө үр ашигтайгаар зарцуулахын тулд төсөв санхүүгийн шинэчлэлийг эрчимжүүлэх, шинэ санхүүгийн механизм, хэрэгслүүдийг туршиж, нэвтрүүлэх шаардлагатай. Тухайлбал, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтийг хөгжлийн зорилтуудад чиглүүлэх хэд хэдэн дэвшилтэт арга, бодлогын шинэчлэлүүдийг стратегид тусгаж өгсөн. Ингэснээр санхүүгийн эх үүсвэрийг үр дүнтэй нэмэгдүүлэхэд түлхэц болно. Эдгээр цогц арга хэмжээг тусгаж, яамдууд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, олон улсын санхүүгийн байгууллагууд, НҮБ зэрэг олон талтай хамтран эл стратегийг боловсруулсан.

Өмнө нь санхүүгийн салбарын стратеги, төсөв, хөрөнгө оруулалт зэрэг салангид олон бодлого гарч байсныг нэгтгэсэн.

Нэгдсэн санхүүжилтийн стратеги боловсруулах ажлыг НҮБ-аас зөвлөж, 70 гаруй улс боловсруулж байгаагийн нэг нь манай улс юм. 2000-2015 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс орнууд төсөв, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрийг голчлон ашиглаж байсныг өөрчилсөн. 2015-2030 он хүртэлх хугацаанд дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн болон санхүүгийн зах зээл дэх хөрөнгийг түлхүү чиглүүлэх зорилгоор үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог (ҮСНТ) бүрдүүлэх, стратеги боловсруулахыг НҮБ-аас зөвлөж, үүнийг нь манай улс нутагшуулж байна. ►

Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх санхүүжилтийн талаар Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэгтэй ярилцлаа.

-Сүүлийн жилүүдэд манай улс тогтвортой хөгжлийн санхүүжилтийн талаар ихээхэн ярих боллоо. Монголын Тогтвортой Санхүүгийн Форумын оролцогчид үүнийг олон талаас нь ярьж байсан. Та тус форум дээр Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн стратегийн төслийг танилцуулсан. Энэ баримт бичгийн талаар манай уншигчдад танилцуулна уу?

-2020 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль батлагдаж, манай улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд нэлээд дэвшил гарсан. Тус хуульд өмнө нь байсан 400 гаруй бодлогын баримт бичгийг багцлан оруулсан юм. Манай улс урт хугацааны хөгжлийн бодлогоо Тогтвортой хөгжлийн зорилтуудтай (ТХЗ0) уялдуулан “Алсын хараа-2050” баримт бичигт тусгаж баталсан. Бид энэхүү баримт бичигт нийцүүлэн дунд болон богино хугацааны бодлогоо тодорхойллоо.

Монгол Улсыг тогтвортой хөгжилд хүргэхэд шаардлагатай санхүүжилтийг бий болгохын тулд Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратегийг боловсруулсан.

► **-Таны дээр дурдсан санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог амжилттай бий болгоход юунд анхаарах шаардлагатай вэ?**

-Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо нь цоо шинээр бий болж байгаа зүйл биш. Одоо байгаа төсөв, санхүү, бодлого төлөвлөлт, санхүүгийн салбар, хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлангийн үйл явцыг хооронд нь илүү уялдаатай болгох, сайжруулах, хөгжлийн бодлого, зорилтуудтай холбох тухай ойлголт юм. Тогтвортой хөгжлийг дэмжсэн санхүүжилтийн орчныг амжилттай бүрдүүлэхэд хэд хэдэн чухал хүчин зүйл бий.

Юуны өмнө, төрийн шийдвэр гаргагч болон зохицуулагч байгууллагуудын идэвхтэй манлайлал, тууштай байдал, оролцоо маш чухал.

Хоёрдугаарт, хөгжлийн зорилтууд болон санхүүжилтийн эх үүсвэрийн уялдааг хангах, томоохон төслүүдийг санхүүжүүлэх хэрэгслүүдийг хөгжүүлэхэд санхүүжилтийн стратеги хэрэгтэй.

Гуравдугаарт, санхүүжилтийн стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх механизмыг олон талт төрийн байгууллагуудын болон хөндлөнгийн хяналтын оролцоотойгоор бий болгох шаардлагатай. ҮСНТ-ны хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хянаснаар санхүүжилтийн урсгал болон бодлогын дэмжлэг нэмэгдсэн эсэхэд дүгнэлт хийх, ямар стратеги амжилттай хэрэгжиж, эсвэл хэрэгжихгүй байгаа талаар нотолгоонд суурилсан шинжилгээ хийх, улмаар бодлого боловсруулах үйл явцад дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ. Түүнчлэн хэрэгжилтийн талаар ил тод мэдээлэх нь хариуцлагыг нэмэгдүүлж, түнш байгууллагуудын хамтын ажиллагаа болон итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал гэж үзэж буй. Иймээс ҮСНТ-ны хяналт, үнэлгээний тогтолцоо, оролцогч талууд болон тэдгээрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох нь амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь болно.

-Хөгжлийн бодлого болон санхүүжилт хоорондын уялдааг сайжруулах тал дээр Сангийн яамны зүгээс ямар ажлууд хийх боломжтой вэ?

-Хөгжлийн төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах, илүү үр дүнд чиглэсэн төсөвлөлт рүү шилжихэд анхаарч байна. Өнгөрсөн жил эрүүл мэндийн салбарт, энэ жилээс боловсрол, соёл, спортын салбарт төсвийн шинэчлэл хийж эхэлсэн. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн дийлэнх нь эмнэлгийн байрны урсгал засвар, эмч, ажилчдын цалинд зарцуулагддаг байсан. Одоо

эмнэлгийн бие даасан байдлыг илүү хангаж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжээд байна. Олон хүн эмчилж, үр дүнтэй ажиллаж байгаа эмч илүү цалин хөлс авах тогтолцоо бүрдэж байна. Ингэснээр хөдөлмөрөө шударгаар үнэлүүлж, урам зоригтой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх боломж нь нээгдэнэ.

Түүнчлэн Сангийн яам өрийн тогтвортой байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэх чиг үүргийнхээ хүрээнд илүү тогтвортой хөгжилд чиглэсэн, урт хугацааны бага хүүтэй өрийн хэрэгслүүдийг түлхүү хэрэглэх, өндөр хүүтэй арилжааны өрийн хэрэгслүүдээс зайлсхийх стратеги баримталж байна. Мөн гадаадын зээл болон төсөл, хөтөлбөрөөр дамжуулан санхүүжилт хийхдээ эдийн засгийн үр ашиг болон нийгмийн ач холбогдлыг нь харгалзан эрэмбэлж, өрийн удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх замаар тогтвортой хөгжлийн зорилт болон төсөв санхүүжилтийн уялдаа холбоог хангаж байна.

-Тогтвортой хөгжлийн санхүүжилтэд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо чухал гэж та дурдсан. Тэгвэл хувийн хэвшил энэ асуудалд хэр ач холбогдол өгч байна вэ?

-Хувийн хэвшил манлайлж ажилладаг гэдгийг онцолж. Ялангуяа, банк, санхүүгийн байгууллагууд маш сайн манлайлж байна. Тухайлбал, 2020 оноос арилжааны банкууд байгаль орчинд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааны ангилал болох “Ногоон таксономи”-г нэвтрүүлсэн. Ингэснээр зээл хүсэгч аж ахуйн нэгж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж байна уу, ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан эсэх зэргийг зээл олгохдоо анхаардаг болсон. Нөгөө талдаа, банк, санхүүгийн байгууллагууд харилцагч нартаа тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүн бүрийн хувь нэмэр чухал гэдгийг ойлгуулж, уриалж байгаа хэрэг.

Одоогоор нийт зээлийн 2-5 хувь нь ногоон зээл байгаа нь маш бага тоо. Цаашид улам нэмэгдэнэ. Түүнчлэн, компаниуд ногоон бонд гаргах, ногоон зээл авахад байгаль орчинд ээлтэй төслийг тодорхойлох, төслөөс хүлээгдэж буй үр дүнг хэмжихдээ “Ногоон таксономи”-ийг суурь болгон ашигладаг. “Ногоон таксономи”-ийг өргөжүүлж, зөвхөн байгаль орчин, хүнд ээлтэй төдийгүй нийгэм эдийн засгийн ач холбогдлыг нь үнэлдэг “Тогтвортой хөгжлийн зорилгын санхүүжилтийн таксономи”-ийг боловсруулж байна.

Төрийн шийдвэр гаргагч болон зохицуулагч байгууллагуудын идэвхтэй манлайлал, тууштай байдал, оролцоо маш чухал.

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тулгамдаж буй асуудалд санхүүгийн салбарын тэргүүлэгч банкууд өөрсдийн санаачилгаар Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллага болон Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас хөнгөлөлттэй санхүүжилт татсан.

Монголын хөрөнгийн бирж НҮБ-ын дэргэдэх Тогтвортой хөрөнгийн биржүүдийн холбоонд 2017 онд элссэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компаниудад Монголын хөрөнгийн зах зээлд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Ингэснээр компаниуд үйл ажиллагааныхаа эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг тодорхойлох, олон нийтэд мэдээлэх, сөрөг нөлөөллийг бууруулах сайн талтай. Энэ нь эргээд компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулах, амжилттай оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлэх юм.

Цаашид хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах хэд хэдэн шинэчлэл хийнэ. Сангийн яамнаас төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барихаар зэхэж байна.

-Улсын төсөв тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэр уялдаж байна вэ?

-2018 оноос эхлүүлсэн төсвийн шинэчлэлийн нэг гол ажил нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан, үр дүнд чиглэсэн төсөвлөлтийг салбар бүрт нэвтрүүлэх юм.

Түүнчлэн жендэрийн мэдрэмжтэй, хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн төлөвлөлтийг туршилтаар хэрэгжүүлж байна. Гол зорилго нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний үр дүнг бүгд эрх тэгш хүртэх ёстой гэсэн зарчимтай. Мөн зээл тусламж, дахин санхүүжилт босгоход тогтвортой хөгжлийн зорилтуудыг өнгөрсөн оноос тусгаж эхэлсэн.

-Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлснээр Сангийн яамны хувьд өмнө нь байгаагүй ямар боломжууд шинээр бий болж байгаа вэ?

-Төсөвт ирэх ачааллыг багасгана. Хөгжлийн бодлогуудыг хэрэгжүүлэхэд төсвийн хэт хамаарлыг багасгаж, хувийн хэвшил болон бусад талуудын оролцоог нэмэгдүүлнэ. Хувийн хэвшилд ч энэ нь шинэ боломж, шинэ зах зээлийг бий болгоно. Өмнө нь төсвөөс санхүүжиж байсан ажлуудыг

хувийн хэвшил рүү чиглүүлснээр төсвийн ачааллыг багасгаж, өр зээлээ бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах, хөгжлийн зорилгодоо хүрэх хурдыг түргэсгэнэ. Нэг ёсондоо, Монгол улс илүү хурдан хөгжих боломж нь бүрдэнэ гэсэн үг.

Мэдээж энэ нь урт хугацааны, олон салбарыг хамарсан реформуудыг шаардана. Тухайлбал, төсвөө тогтвортой хөгжилд бүрэн чиглүүлэх, үр ашгийг нь нэмэгдүүлэхийн тулд дээр дурдсан төсвийн төлөвлөлтийн шинэ аргачлалыг туршиж байна.

Төрийн өмчит байгууллагуудын шинэчлэлийг энэ онд хийхээр төлөвлөсөн. Улсын хэмжээнд 40 гаруй их наяд төгрөгийн хөрөнгөтэй 400 гаруй орон нутгийн болон төрийн өмчит компани бий. Энэ оны улсын төсөвт нийт 18 их наяд төгрөг бий. Төрийн өмчит компаниуд тогтвортой хөгжлийн зорилгуудыг хурдасгахад хэр их нөлөө үзүүлж чадах нь үүнээс харагдаж байна. Тэр дундаа, төрийн өмчит банк санхүүгийн байгууллагууд, тогтвортой хөгжилд чиглэсэн санхүүжилт олгоход маш чухал үүрэгтэй. Хөгжлийн банкны шинэчлэлийн хүрээнд үйл ажиллагаанд нь тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг нэвтрүүлэх, Төрийн банкныг шинэчлэн үйл ажиллагааг нь ЖДҮ-ийг дэмжихэд чиглүүлэх зэрэг олон шинэчлэлийг стратегид тусгасан.

-Манай улсын хувьд олон бодлого, хөтөлбөр баталдаг ч хэрэгжилт хангалтгүй байна гэсэн шүүмжлэл дагуулдаг. Тогтвортой хөгжилд хүрэх, таны дурдсан бодлогын шинэчлэлүүдийг хэрхэн хянаж, хэн хариуцах вэ?

-Тогтвортой хөгжилд хүрсэн эсэх, ямар ахиц дэвшил гарсныг хэмжихийн тулд НҮБ-аас нийтдээ 231 нийтлэг шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Улс орнууд эдгээр шалгуур үзүүлэлтийг өөрсдийн нөхцөл байдалтай уялдуулан түвшнээ тодорхойлно. Манай улс ч өөрийн онцлогт тохирсон үзүүлэлтүүдээ боловсруулсан. Энэ асуудлыг ойрын хугацаанд УИХ-аар хэлэлцэнэ.

Харин тогтвортой хөгжилд зарцуулж буй санхүүжилт нэмэгдэж байгаа эсэхийг хянахад өмнө нь дурдсан ТХЗ-ын санхүүгийн таксономийг боловсруулж батлах нь маш чухал. ТХЗ-ын санхүүгийн таксономи нь байгаль орчны асуудлуудаас гадна ядуурлыг бууруулах, эрүүл мэнд болон чанартай боловсролыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй зэрэг нийгэм болоод хүн рүү хандсан тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийг хангахад чиглэсэн. Энэхүү санхүүгийн таксономийг хэрэгжүүлж эхэлснээр

Төрийн өмчит банк санхүүгийн байгууллагууд, тогтвортой хөгжилд чиглэсэн санхүүжилт олгоход маш чухал үүрэгтэй.

► байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжилд чиглэсэн нийгмийн төслүүдэд олгосон зээлийн статистик, мэдээлэл гаргах боломжтой. Үүн дээр тулгуурлан аль салбар луу санхүүжилтийн урсгал чиглэж байгааг, санхүүжилтээ хааш нь чиглүүлэх шаардлагатай зэргийг дүгнэж бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах юм.

Үндэсний Аудитын газраас ТХЗ-ын гүйцэтгэлийн аудит хийх, УИХ-ын холбогдох байнгын хорооуд дээр тодорхой зорилтуудын хүрээнд хэрэгжилт, санхүүжилтээр олон нийтийн оролцоотой, нээлттэй хэлэлцүүлэг хийх боломжтой. Түүнчлэн УИХ-ын Тогтвортой хөгжлийн дэд хороо хяналт тавьж, үнэлгээ зөвлөмж өгнө.

-Дэлхийн бусад улсын адил манай орон ч уур амьсгалын өөрчлөлтөд өртөж байна. ҮСНТ-ны стратегийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны тулгамдаж буй асуудалтай тэмцэхэд хэрхэн анхаарах вэ?

-ҮСНТ-ны санхүүжилтийн стратегийн хүрээнд байгаль орчны татварын шинэчлэл, тэр дундаа ногоон татварын тогтолцоог бий болгох зэрэг үе шаттай хэрэгжүүлж болох арга хэмжээнүүд тусгагдсан. Төрийн болон хувийн хэвшлийн компаниуд үйл ажиллагаандаа “Байгаль орчин, нийгэм, засаглалын стандартууд”-ыг нэвтрүүлснээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ.

Мөн байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр лүү аажмаар шилжих, үүний тулд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилах шийдлийг санал болгож буй.

Агаарын бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд “Ногоон зээл”-ийг түлхүү гаргахад арилжааны банкууд анхаарах, төрөөс энэ чиглэлд ажиллаж байгаа аж ахуй нэгжийг дэмжих, хөнгөлөлт, урамшуулал олгох зэрэг бодлогын дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

-Манай улсын эдийн засаг, экспорт, төсвийн орлогод уул уурхайн салбар голлох байр суурь эзэлдэг. Тогтвортой хөгжлийн санхүүжилтэд эл салбарын оруулах хувь нэмрийг хэрхэн дүгнэж байна вэ?

-Байгалийн баялгийг ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах нь зөв. Гэхдээ үйл ажиллагаа нь байгаль орчин, ан амьтдад ээлтэй, нөхөн сэргээлтийг хангалттай сайн хийдэг, тогтвортой уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой.

Цаашид уул уурхайн компаниудад үйл ажиллагаа

явуулах зөвшөөрөл олгохдоо байгаль орчинд ээлтэй байх, нөхөн сэргээлтийг өндөр түвшинд хийх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж ажиллах талаар бодлогын бичиг баримтад нь тусгах нь зүйтэй. Мөн хөрөнгө оруулагчдыг уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэхэд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих хэрэгтэй.

Сүүлийн үед уул уурхайн компаниуд ногоон хөгжил, нийгмийн хариуцлагад ихээхэн ач холбогдол өгдөг болсон. Тухайлбал, Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвх санаачлагатай оролцож байна.

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шууд зогсоож, хорихоос илүү сөрөг нөлөөг бууруулахад хамтран ажиллах болно.

Уул уурхайн салбар нь цахилгаан эрчим хүч, түлш, шатахууны томоохон хэрэглэгч, энэ утгаараа хүлэмжийн хийн ялгаруулалт ихтэй. Ойролцоогоор 600-700 мянган тонн нүүрсхүчлийн хийг ялгаруулж байна. Цаашид энэ хэмжээ хоёр дахин нэмэгдэхээр байгаа тул уул уурхайн компаниуд эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, машин механизм ашиглах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулалт хийж, өөрсдийн цахилгааны хэрэглээгээ хангах зэргээр хүлэмжийн хийг бууруулах боломжтой.

Эрчим хүчний үр ашгийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх сонирхол гадаадын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудад их байгаа нь бас нэг боломж юм. Манай уул уурхайн компаниудад байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж авах, үйл ажиллагаагаа тогтвортой болгоход чиглэсэн гадаад санхүүжилт татах боломж өндөр байна.

-2030 онд Монгол улс НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд тодорхойлсон үндэсний хөгжлийн зорилтуудад хүрэх боломжтой юу?

-Хөгжлийн зорилтуудад хүрэхэд улс орны хэмжээнд зөв стратеги, бодлогын тогтвортой байдал, залгамж холбоо чухал. Дэлхий нийтээрээ хамтран ажиллаж, харилцан туршлага солилцож, бусдын сайн туршлагыг улс орныхоо онцлогт тохируулан нутагшуулж байна. Манай улсын хувьд ч гэсэн чамгүй хичээл зүтгэл гаргаж байгаа тул 2030 он гэхэд томоохон ахиц дэвшил гарна гэдэгт бүрэн итгэлтэй байна. ■

Манай уул уурхайн компаниудад байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж авах, үйл ажиллагаагаа тогтвортой болгоход чиглэсэн гадаад санхүүжилт татах боломж өндөр байна.

Цай Вэньруй: Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд саруул ирээдүй бий



Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаа хэдий ч Хятадын эдийн засаг тогтвортой сэргэж буйн зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь эрс өссөн байна. Мөн Азийн хамгийн том хөрөнгө оруулагч улсын тэргүүн эгнээнд БНХАУ бичигддэг. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалт татах сайн туршлага болоод Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийн талаар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруитай “Mongolian Economy” ярилцлаа.

–Сэтгүүлийн маань урилгыг хүлээн авч ярилцлага өгч буй Элчин сайд танд талархал илэрхийлье. БНХАУ гадаадын хөрөнгө оруулалт татаж буй үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэх байр суурь эзэлдэг. Тухайлбал, 2020 онд АНУ-ыг давж хамгийн их гадаадын шууд хөрөнгө оруулалт татсан улс болсон (эх сурвалж: UNCTAD). Хөрөнгө оруулалт ийн татаж буй БНХАУ-ын “нууц” нь юунд оршиж байна вэ?

–2020 онд БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулалтыг бодитоор ашигласан тоо хэмжээ 144 тэрбум 370 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.5 хувиар өссөн үзүүлэлт юм. 2021 оны нэгээс арваннэгдүгээр сар хүртэл БНХАУ-ын

гадаад хөрөнгө оруулалтын бодит хэрэглээ 157.2 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.4 хувиар өссөн.

Хятад улсад гадаадын хөрөнгө оруулалт татах үндсэн зургаан давуу тал бий. Нэгдүгээрт, нийгэм, улс төрийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын орчныг тасралтгүй сайжруулж, гадаадад нээлттэйгээр хөгжих боломжийг тасралтгүй өргөжүүлж байна. Хоёрдугаарт, Хятад улс дэлхийн үйлдвэрлэлийн төв болж, орчин үеийн үйлчилгээний салбарын эрэлт хэрэгцээ их хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой.

Гуравдугаарт, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг орчин үеийн дэд бүтэц маш сайн хөгжсөн. Зарим салбарын үйлчилгээ өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн нь үйлчилгээний аутсорсинг хөгжүүлэх сайн бааз суурь болдог. Дөрөвдүгээрт, Хятадын макро эдийн засгийн өсөлт хурдацтай байна.

Тавдугаарт, гадаадын хөрөнгө оруулагчид том зах зээлийг сонирхох нь нэмэгдэж байна. Судалгаанаас харахад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн 90 гаруй хувь нь Хятадын зах зээл рүү чиглэж “Хятад улсад, Хятадын зах зээлд” гэсэн зорилт тавин ажиллаж байна. Манай улсын 1.4 тэрбум хүн амын 400 гаруй сая нь дундаж давхаргад хамаардаг бөгөөд иргэдийн хэрэглээний зах зээлийн цар хүрээ, өсөлтийн чадавхыг юутай ч зүйрлэшгүй. Үүнээс гадна манай улсын үйлдвэрийн байгууламжуудын иж бүрэн дэд бүтэц, хүний нөөцийн хангалттай байдал зэрэг цогц давуу тал нь Хятад улсыг сонирхох гадаадын хөрөнгө оруулагчдын тоог өдрөөс өдөрт нэмсээр байна.

Зургадугаарт, гадаадын хөрөнгө оруулагчдын Хятад улсад итгэх итгэл, хүлээлт тогтвортой байдаг. Гадаадын хөрөнгө оруулалттай 3000 гаруй аж ахуйн нэгжийн 93.3 хувийнх нь ирээдүйн хөгжлийн хэтийн төлөв өөдрөгөөр харагдаж буйг БНХАУ-ын Худалдааны яамнаас хийсэн санал асуулгын дүн харуулж байна.

–Хятадын хөрөнгө оруулалт, бизнесийн эрх зүйн орчин ойрын тав, арван жилийн хугацаанд таатай байна гэж Дэлхийн банкны тайланд ▶

Манай улс гадаадын хөрөнгө оруулагчдад шударга, эрх тэгш байдлыг хангах бүрэн баталгаа өгдөг.

► **дурдсан. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд хууль, эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлсэн бэ?**

-Манай улс гадаадын хөрөнгө оруулагчдад шударга, эрх тэгш байдлыг хангах бүрэн баталгаа өгдөг. Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахын тулд сайн ажилласан. Мөн үйлчилгээний механизмыг боловсронгуй болгож байна. Манай улс XIII таван жилийн хугацаанд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, бизнесийн орчныг сайжруулах журам болон бусад дагалдах хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлсэн. Бизнесийн орчныг таатай болгох хууль эрх зүйн баталгаа болохын зэрэгцээ тусгай зөвшөөрлийг цөөлөх, хяналтын тогтолцоонд инновац оруулах, чанарын өндөр түвшний үйлчилгээ үзүүлэх гэсэн шат дараалсан арга хэмжээг авч, бизнесийн орчныг улам сайжруулсаар байна. Бизнесийн орчинд сайн нь биш, хамгийн шилдэг нь л оршин тогтнож чадна гэсэн үг байдаг.

-БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс 2019 онд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тухай 722 тоот тогтоолыг баталж, 2020 оноос мөрдөж эхэлсэн. Эл хуулийн гол онцлох шинэчлэлүүд юу вэ?

-Хууль нь нийт зургаан бүлэг 42 зүйлтэй, БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр шууд болон шууд бусаар гадаадын иргэн, хуулийн этгээдийн байгуулсан хуулийн этгээдэд үйлчилнэ. Бизнесийн орчныг сайжруулах журам нь Намын төв хороо, Төрийн зөвлөлийн гаргасан тусгай зөвшөөрлийг цөөлөх, хяналтын тогтолцоонд инновац оруулах, чанарын өндөр түвшний үйлчилгээ үзүүлэх гэсэн заалтын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, бизнесийн орчныг таатай болгох тухай шийдвэрийг хэрэгжүүлэн, төрийн чиг үүргийн томоохон өөрчлөлтийг дэмжиж, шударга, ил тод, урьдчилан таамаглах боломжтой бизнесийн орчныг бий болгож, зах зээлийн хүчин чадал, нийгмийн бүтээлч байдлыг дэмжих зорилгоор боловсруулсан зохицуулалт юм. Уг журмыг баталсан нь манай улсын бизнесийн орчны тогтолцооны түүхэнд асар их ач холбогдолтой гэж үзэж байгаа. Энэ бол манай улсын бизнесийн орчныг сайжруулах тогтолцоо шинэ шаганд гарсны илрэл. Захиргааны тусгай журам боловсруулж зах зээлжсэн, хуульчилсан, олон улсын хэмжээний бизнесийн орчныг сайжруулж, Засгийн газраас гаргах хууль тогтоомжоор салбар бүрийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэхэд нь эрх зүйн орчны баталгаа өгөх юм.

Энэ бүхэн нь шинэчлэлийг өргөн хүрээнд явуулах, шударга өрсөлдөөнийг дэмжих, эдийн засгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, чанартай хөгжлийг дэмжихэд чухал нөлөө үзүүлнэ. Бизнесийн орчныг сайжруулах журмын зорилт нь захиргааны менежментийн тусгай зохицуулалтыг боловсруулахад оршино. Хятад улс бизнесийн орчныг сайжруулахад өндөр ач холбогдол өгч, цаашлаад тууштай байдлаа дэлхий нийтэд харуулахыг зорьж буй. Түүнчлэн бизнесийн орчныг сайжруулах тухай бүх шатны захиргаа, төрийн байгууллага болон олон нийтийн ухамсрыг нэмэгдүүлэн, бизнесийн орчны уур амьсгалыг нэн таатай болгож, зах зээлийн оролцогч талуудын итгэлийг сэргээхэд хүчин чармайлт гаргаж байна. Тус журам нь зах зээлийн шударга, нээлттэй, ил тод дүрмийг бий болгох, сайжруулахад чиглэсэн.

Тухайлбал, бизнесийн бүх тоглогч зах зээлийн өрсөлдөөнд хуулийн дагуу шударга оролцох нөхцөлийг төр баталгаажуулж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд адил тэгш үйлчилж байх нөхцөлийг тодотгосон нээлттэй, ил тод зохицуулалтын дүрэм, системийг боловсронгуй болгох зэргийг тодорхой заасан.

-Монгол Улс ч мөн адил хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлд ихээхэн анхаарал хандуулж байна. Хөрөнгө оруулагчдад ээлтэй улс болохын тулд манай улс юунд анхаарах хэрэгтэй гэж та бодож байна вэ?

-Цар тахлын нөлөө дэлхийн эдийн засагт ноцтой цочрол өгч, томоохон сорилтуудыг авчирсан он жилүүд өнгөрч байна. Монгол Улсын Засгийн газар цар тахалтай тэмцэх ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихтэй уялдуулж, бизнесүүдийг шат дараатай сэргээсэн. Улмаар 2021 онд гадаадын хөрөнгө оруулалтыг татах явц аажмаар сэргэж, хөрөнгө оруулагчдын хүлээлт, итгэл аль аль нь сайжирсан байна.

Сүүлийн жилүүдэд Монголын төр засгаас бизнесийн орчныг сайжруулахад ихээхэн ач холбогдол өгч, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталж, хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг эрх тэгш нөхцөлөөр хангаж, хөрөнгө оруулалтыг либералчлах, хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хөрөнгө оруулалт хариуцсан эрх бүхий байгууллагууд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх үйлчилгээгээ сайжруулах, шударгаар хандах, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, визний үйлчилгээг

Хятадын Худалдааны яамны статистик мэдээнээс харахад 2020 оны эцэс гэхэд Хятадаас Монгол улсад оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гурван тэрбум 240 сая ам.долларт хүрсэн байна.

▶ хөнгөвчлөх шаардлагатай гэж бодож байна. Мөн гадаадын ажиллах хүчний квотыг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг үргэлжлүүлэн сайжруулах, гадаадын хөрөнгө оруулагчдын хүлээлт, Монгол Улсад итгэх итгэлийг тогтворжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч ажиллахыг хүсэж байна.

-Монгол Улсын уул уурхай, барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтаар БНХАУ тэргүүн эгнээнд жагсдаг. Цаашид Хятадын хөрөнгө оруулагчид Монголын аль салбарт хөрөнгө оруулах сонирхолтой байна вэ?

-Хятад, Монгол хоёр орны стратегийн түншлэлийн харилцаа улам бүр гүнзгийрч байгаад баяртай байна. Энэ үед хоёр орны хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд түлхэц өгөх, бэхжүүлэх нь Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцыг дэмжихэд чухал ач холбогдолтой. Хятад, Монгол хоёр газарзүйн хувьд зэргэлдээ оршдог, зам тээврийн хялбар дөхөм нөхцөлтэй, эдийн засгийн хувьд харилцан биенээ нөхөх давуу талтай. Хятад улс нь Монголын хөрөнгө оруулалтын чухал эх үүсвэр байсаар ирсэн. Монгол улс бол "Бүс ба Зам"-ын бүтээн байгуулалтын хойд шугамын чухал тулгуур бүс нутаг.

Хятадын Худалдааны яамны статистик мэдээнээс харахад 2020 оны эцэс гэхэд Хятадаас Монгол улсад оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гурван тэрбум 240 сая ам.долларт хүрсэн байна. Хөрөнгө оруулалтын салбарыг бүтцээр нь авч үзвэл ашигт малтмалын хайгуул, ашиглалт, барилгын материал, эрчим хүч зэрэг салбарт голчлон төвлөрч байна. Тодруулбал, БНХАУ-аас Монгол Улсад оруулж буй хөрөнгө оруулалт нь голчлон нөөц баялаг, ажиллах хүч шаардсан үйлдвэрлэлд төвлөрч байгаа бол санхүү, ухаалаг үйлдвэрлэл гэх мэт технологи, хөрөнгө оруулалт их шаардсан үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалт харьцангуй бага, хөрөнгө оруулалтын бүтэц нь харьцангуй нэг талт байна.

Хятадын хөрөнгө оруулагчид Монголын уул уурхайн салбараас гадна нийтийн хоолны үйлчилгээ, аялал жуулчлал, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, нэхмэл эдлэл, хувцас, мэдээлэл, харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулалт хийхийг үргэлж сонирхож ирсэн. Цаашид Хятадын хөрөнгө оруулалттай олон аж ахуйн нэгж эдгээр салбарт орж, хамтын ажиллагааны шинэ онцлох үйл явдлуудыг бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

-Хятадын бизнес эрхлэгчид Монголд бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээл юу байна

вэ? Хятадын хөрөнгө оруулагчдаас хэр их санал гомдол ЭСЯ-нд ирдэг вэ?

-Монголын улс төрийн байдал ерөнхийдөө тогтворжиж, хууль эрх зүйн болон бизнесийн орчин сайжирч Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд Монголд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсээр байгаа. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд ерөнхийдөө хэвийн байгаа ч зарим нэг саад бэрхшээлтэй тулгардаг. Манай Элчин сайдын яаманд Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн гомдол цөөн ирдэг. Гэхдээ уул уурхайн компаниудад тулгардаг байгаль орчныг хамгаалах шалгалт, татварын хяналт шалгалт, нийгмийн даатгалтай холбоотой гомдол санал ирдэг.

Мөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зарим нэг төрийн бус байгууллага хууль бус, хөндлөнгөөс оролцох зэрэг асуудал үүсдэг. Элчин сайдын яам болон компанийн түвшинд эрх бүхий байгууллагатай уялдаа холбоотой ажиллаж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалснаар Хятад компаниудын Монгол улсад хөрөнгө оруулах итгэл, урам зориг нэмэгдэх болно.


-Элчин сайд Та манай хоёр орны цаашдын хөрөнгө оруулалтын орчныг хэрхэн төсөөлж байна вэ?

-Олон улсын эдийн засгийн төвөгтэй нөхцөл байдал болон Ковид-19 цар тахлын халдвар намжихгүй байгаатай холбоотойгоор Хятад-Монголын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд түр зуурын бэрхшээл байна. Түүнчлэн, хоёр талын хилээр гарах, орох хяналтын арга хэмжээ, хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан нь зах зээлийн судалгаа, бизнесийн хэлэлцээр, төслийн тендер зэрэг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үйл явцыг түр хойшлуулж, хөрөнгө оруулалтын эрч хүч, үр ашгийг бууруулж байна.


Гэхдээ бид хямралыг боломж болгон хувиргаж, өөдрөг бус нөхцөл байдлын далд боломжуудыг нээх хэрэгтэй. Хоёр талын хөрөнгө оруулалтын орчин тасралтгүй сайжран, хөрөнгө оруулалтын таатай байдал нэмэгдэхийн хэрээр аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зөвшөөрөл, шаардлагыг хялбаршуулах хэрэгтэй. Тэдгээрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлж, зах зээлд чиглэсэн, хуульчлагдсан, олон улсын түвшинд хүрсэн бизнесийн орчныг бүрдүүлснээр Хятад, Монгол хоёр улсын аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулах, бизнес эрхлэхэд таатай орчин бүрдэх нь дамжиггүй. ■

Бид хямралыг боломж болгон хувиргаж, өөдрөг бус нөхцөл байдлын далд боломжуудыг нээх хэрэгтэй.

БНХАУ-аас Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалтын орох урсгал (сая ам.доллар)




БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалт, салбараар (1990-2021 оны нэгдүгээр улирал, мянган ам.доллар)




Монгол Улсад бүртгэлтэй БНХАУ-ын компанийн тоо, салбараар (1990-2021 оны нэгдүгээр улирал)



Гадаад худалдааны бараа эргэлт (мянган ам.доллар)



БНХАУ руу экспортолж буй голлох бүтээгдэхүүн (2022 оны эхний 2 сарын байдлаар, мянган ам.доллар)



БНХАУ-аас импортолж буй голлох бүтээгдэхүүн (2022 оны эхний 2 сарын байдлаар, мянган ам.доллар)



Хөрөнгө цаашаа Монгол

А.АМАРСАЙХАН
Зохиолч, шог
зураач

Айлын аав гадаадын хөрөнгө оруулалт татаад, өөрийн оюун ухаанаар смарт технологи боловсруулж, нано бүрээс үйлдвэрлэхээр ажилдаа орж байх үед манай аав “утаагүй зуух” хэмээгч үлгэр ярьж эхэлж билээ. Бусад айл гадаадын хөрөнгө оруулалт татахын төлөө онцгой анхаарч, хөрөнгө орж ирэх хамгийн таатай нөхцөл бүрдүүлэхийн төлөө ухаан зардаг. Гэтэл манайх гэдэг айл эсрэгээрээ, яавал гадны баяныг үргээж хөөх вэ хэмээн толгой гашилгах нь ад мөрийн.

2012 онд уул уурхай огцом цойлж өсөхөд, бусад айл яавал үүнээс илүү ашиг олох вэ, яавал уул уурхайдаа гадны хөрөнгийг татах вэ хэмээн өдрийн бодол шөнийн зүүд болсон. Гэтэл манайх гэдэг айл яалаа? Тэр гайхамшигт өдрүүдэд Ерөнхий сайдын довжооноо дэлхийн акул групп корпорациудын эзэд, захирлууд оочерлож байсан гэлцдэг. Харин аав маань алтны 68 хувийн онцгой татвар санаачилж, стратегийн орд гэх жагсаалт баталж, гадны хөрөнгийг үлдэн хөөхийн төлөө шүдээ зуун зүтгэсэн нь гаж. Улс даяараа улс төржиж, “Монголын баялгийг тонон дээрэмдэх бузар санаатнууд зайл!” хэмээн сүрт жагсаал хийсэн. Санаснаар нь болж, Рио Тинто гэх үйл лайтай ганцаас бусад нь бүгд үргээд дайжчихсан. Одоо харин учиргүй харуусч, “алтан боломжоо алдаж дээ” гээд шүдгүй амаа бариад, үсгүй дагзаа маажгаад сууж байна.

Ингээд гэнэт ухаан орж, гадны хөрөнгө татахын тулд сайн хууль хэрэгтэй гэж орилоод, гайгүй сайн хууль баталсан. Гэвч түүнийгээ таг мартчихсан. Хуулийг хэрэгжүүлэх механизм, орчин гэгч зүйл хэрэгтэйг огт ойлгоогүй нь даанч мулгуу. Одоо “Тайгүй сайн хуультай байтал, гадныхан яагаад орж ирсэнгүй вэ?” гээд л гайхаж, ангайж суугаа.

Урд айлын аав хэдэн жилийн өмнөөс дэлхийн хамгийн хурдан галт тэргийг улсдаа бүтээнэ хэмээн зориод, гадны хөрөнгө технологийг оруулахаар судалж эхэлсэн. Хэдхэн жилийн дараа урд айлын хотуудын хооронд соронзон

дэртэй, хэт өндөр хурдны галт тэрэг 600 км/цаг салхи татуулахад, манай аав Зайсангаас хотын төв рүү саадгүй хүргэх “дүүжин тээвэр” хэмээгч шинэ үлгэр бодонгоо, “умаа хум утаагүй зуух” гэгч тарниа умшиж л суусан. Цаашаа хэдэн жил дүүжин тээврээ ярихыг нь бурхан буг хоёр ч хэлж мэдэхгүй.

Хол саахалт айлын аав дэлхийн брэндийг өөрийн хүүхдийн гараар хийлгэх санаа сэдээд, гадны брэнд үйлдвэрийг оруулж ирэхийн төлөө самбаа сүйхээ гаргасан. Одоо тэднийд үйлдвэрлэсэн “Nike” пүүз, “Sony” зурагтыг дэлхий даяараа хэрэглэж байна. Харин манай аав “дүүжин тээвэр”-ээ “хошгиороо дагшаа найрал” хөгжмийн дэвсгэр дээр улам уран гоё уншдаг болж билээ.

Бас нэгэн айлын аав гаднын хөрөнгө оруулалт татаад, орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлээд, төдөлгүй бараг л бүх хүн амаа орон сууцжуулж, улсаа баян болгож чадсан байтал, манай аав өнөөх л үлгэрээ яриастай.

Айлын аав гаднаас хөрөнгө босгоод өвөл халдаг зам тавьж байхад, манай аав “Дарханы зам ум мааний бад ми хум” гэгч тарни шинээр сураад, дүнгэнүүлж эхэлсэн. Тун удахгүй айлын хотуудад гадны хөрөнгө оруулалтаар бүтээсэн дрон такси нисэж эхлэхээр барахгүй, графит дэлгэц бүтээж, цаас шиг нимгэн смарт утас үйлдвэрлэдэг болно. Харин тэр цагт манай аав “үүлтэй тэнгэрийн доогуур, үзүүртэй модны дээгүүр дүүлэн нисдэг тээвэр”-ийн шинэ хувилбар тарнитай болсон сууна гэдэг 100 хувийн магадлалтай.

2062 онд айлын аав гадны хөрөнгө оруулж, үр хүүхдээ сансарт амраадаг, Номхон далайн ёроолд сувилуулдаг, саран дээр салхилуулдаг болно. Санчир гарагт гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулсан био соронзон хүлэмжиндээ алим жимс ургуулснаа нисгэгчгүй пуужингаар тээвэрлэж авчраад, ач зээгээ баярлуулна. Харин манай аав аанай л “үүлтэй тэнгэрийн доогуур”-аа урнаар умшихуйд, үр хүүхэд ах дүүс нь 1806 онд амьдарч асан эсгий гэртээ халтартаад л, хөөрхий эхнэр нь 1953 онд барьсан модон жорлондоо чичрэн сууна. ■

Айлын аав гаднаас хөрөнгө босгоод өвөл халдаг зам тавьж байхад, манай аав “Дарханы зам ум мааний бад ми хум” гэгч тарни шинээр сураад, дүнгэнүүлж эхэлсэн.



Улс даяараа улс төржиж, "Монголын баялгийг тонон дээрэмдэх бузар санаатнууд зайл!" хэмээн сүрт жагсаал хийсэн.

Дэд бүтэц

Гацаанаас гаргах ган замууд



Цар тахлаас үлдэж буй хамгийн том сургамж юу вэ гэж асуувал хариулт нь маш тодорхой. Дэд бүтцээ сайжруулах шаардлагатай гэж эдийн засагч, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид хэлэх нь дамжиггүй. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөж, Хятад улсын эрэлт урьд байгаагүйгээр тэнгэрт тулсан үед манай экспорт хумигдсан. Энэ нь ердөө дэд бүтэц муугийнх. Харин бидний алдсан орон зайд ОХУ, АНУ, Индонез зэрэг улс гол тоглогч болсон нь бидэнд маш том дохио өгөв.

Монголын эдийн засаг 70 гаруй жилийн турш УБТЗ болон тоос татуулсан хүнд даацын машины ачаан дээр тогтож ирсэн гэвэл хилсдэхгүй. Тэгвэл 2022 онд удаан хүлээсэн төмөр замууд ашиглалтад орж, зам тээврийн салбарт шинэ эргэлт авчрах болно.

Тодруулбал, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.2 км хэвтээ тэнхлэгийн төмөр зам болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км төмөр замуудыг бүрэн ашиглалтад оруулна. Эдгээр нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортод томоохон нөлөө үзүүлээд зогсохгүй, байгаль орчны доройтол, тоосжилт, цөлжилт, агаарын бохирдлыг бууруулах олон талын ач холбогдолтой.

Уул уурхайн бүлэг ордыг түшиглэн барьсан

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглаж эхэлснээр ойролцоох ашигт малтмалын ордууд нь эдийн засгийн эргэлтэд орж, 1500 гаруй байнгын ажлын байр бий болно гэсэн тооцоо бий. Харин Тавантолгойн-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тухайд, манай улсын экспортын гол гарц болох зам. Тус төмөр замыг Хятадын талын төмөр замтай аль цэгээр холбох нь олон жилийн турш тодорхойгүй байсан ч холбох цэгээ тогтож чадсан нь төмөр замын бүтээн байгуулалтыг урагшлуулах чухал алхам болсон юм.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Улстөржилт, талцлаас болж 12 жил төмөр замаа тавьж чадаагүй. Энэ хэрээр Монгол Улс их хэмжээний орлого, боломжоо алдсан. Цаашид ийм байдал давтагдах ёсгүй” хэмээн хэлээд төмөр замыг хугацаанд нь ашиглалтад оруулахад Засгийн газрын зүгээс онцгойлон анхаарч буйгаа илэрхийлсэн.

Зүүнбаян-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилдээ 30-50 сая тонн нүүрс экспортолж, Тавантолгойн бүлэг орд орчмын уурхайн олборлолт 2-3 дахин нэмэгдэнэ. Мөн нүүрсний тээврийн зардал тонн тутамд дөрөв дахин буурч найм орчим ам.доллар болно гэж тооцжээ.

Ийнхүү энэ онд төмөр замын түүхэн бүтээн байгуулалтууд ашиглалтад орохын зэрэгцээ тус салбарт ахин дөрвөн том төсөл хэрэгжинэ. Тодруулбал, энэ онд бүтээн байгуулалт нь эхлэх Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам нь Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд 281 км үргэлжилж, БНХАУ-ын хилийн Мандал боомттой холбогдоно. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам баригдсанаар ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн төв болох Бугат хот руу нийлүүлэх төмрийн хүдэр, нүүрсний экспорт нэмэгдэнэ. Тэр дундаа төмрийн хүдрийн экспортын хэмжээ 2-3 дахин өсөх боломжтой юм.

Дараагийн онцлох бүтээн байгуулалт нь Хөт-Бичигт чиглэлийн 200 км төмөр зам. Зүүн босоо тэнхлэгийн төмөр замыг байгуулах энэхүү томоохон төсөл транзит тээврийн гарцыг нээх, Монгол-Орос-Хятад гурван улсын бүс нутгийн ►

Энэ онд Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудыг бүрэн ашиглалтад оруулна.

► хөгжилд бодитой хувь нэмэр оруулах юм. Одоогоор Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замыг 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Зүүн босоо тэнхлэгийн төмөр замтай зэрэгцэн баруун босоо тэнхлэгийн төмөр замын бүтээн байгуулалт ч эхэлнэ. Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлд 1255 км үргэлжлэх эл төмөр замыг “Монголын төмөр зам” ТӨХК гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, төмөр зам дагуу уул уурхайн лиценз эзэмшигч компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

Энэ жил төмөр замын салбарт өрнөх бүтээн байгуулалт үүгээр зогсохгүй. Нийслэлийн түгжрэл, хөдөлгөөний аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлэх Богдхан төмөр замын төсөл оны онцлох бүтээн байгуулалтад зүй ёсоор багтаж байна. Богдхан төмөр замын шугам нь УБТЗ ХНН-ийн гол замаас Рашаант өртөөнөөс салаалан Богдхан уулын урдуур тойрч, Мааньт өртөөтэй холбогдох юм.

Өдгөө УБТЗ нь Монгол Улсын импорт, экспортын ачаа тээврийн 70 гаруй хувийг дангаар гүйцэтгэж буй. Энэ дунд аюултай ачаа, бараа ч бий. Гэтэл энэ их түгжрэлийн хажуугаар хот дундуур аюултай ачаа тээвэрлэх нь тийм ч таатай биш. Тиймээс Богдхан төмөр замаар ачаа тээврийн вагон зорчуулж, хот дундуур зорчигч тээврийн вагон аялуулах нь хамгийн оновчтой шийдэл юм. 146 километр үргэлжлэх тус төмөр зам ашиглалтад орсноор нийслэлийн төвд байрлах тээвэр логистикийн болон худалдааны томоохон төвүүдийг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх боломж бүрдэнэ. Мөн Богдхан төмөр замыг Улаанбаатар төмөр замтай холбох учраас оператор нь УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэг байна гэсэн хүлээлт байна.

Ийнхүү 2022 он төмөр замын салбарынхны хувьд түүхэн хуудаснаа тодоор тэмдэглэгдэх онцгой жил болох нь. Энэ хэрээр төмөр замын салбарт боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн анхаарч байна. Ойрын таван жилийн хугацаанд энэ салбарт 25 мянга шахам мэргэжилтэн бэлтгэнэ гэсэн тооцоо судалгаа бий. Мөн төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч компаниудад тун ээлтэй цаг үе ирж буйг тус салбарынхан онцолж байна.

Төмөр замын бүтээн байгуулалтаас гадна томоохон автозамуудын ажил үргэлжилнэ.

Тухайлбал, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам, Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн ажлуудыг онцлох хэрэгтэй. Мөн авто замын бүтээн байгуулалттай зэрэгцээд цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц байгуулна.

2022 онд гараанаасаа хөдлөх өөр нэг чухал төсөл нь хилийн боомтуудыг хурдны замаар холбох төсөл юм. Энэ ажил Алтанбулаг-Замын-Үүд боомтуудыг холбосон 987 километр хурдны зам барихаас эхэлнэ. Мөн орон нутагт авто замын бүтээн байгуулалт, засвар шинэчлэлт өмнөх жилүүдийн жишгээр үргэлжлэх бол Улаанбаатар хотод ч онцлох бүтээн байгуулалтууд өрнөнө. Тухайлбал, Толгойт, Баянхошуу, Сэлбэ, Дарь-Эх зэрэг дэд төвүүдийг холбосон 72 километр “Их тойруу” хурдны зам барих ажлыг энэ оноос эхлүүлэхээр төлөвлөжээ.

Мөн энэ жил нийслэлийн түгжрэлийг шийдэхэд зориулж, улсын төсвөөс анх удаа 420 тэрбум төгрөг төсөвлөсөн. Энэ бол түгжрэлд зарцуулсан 10 жилийн хөрөнгөтэй дүйцэхүйц хэмжээний санхүүжилт юм. Тус санхүүжилтээр Улаанбаатар хотын нийтийн тээврийг бүрэн шинэчилж, тулгуурт гүүрэн байгууламж бүхий нийтийн тээврийн хэрэгслийг гурван чиглэлд 41 км зайд барих ажлыг эхлүүлнэ.

Дэд бүтцийн эдгээр төслийн үр дүнд 2025 он гэхэд 285 мянган ажлын байр бий болж, Улаанбаатарыг зорьсон их нүүдэл багасаж, хөдөө орон нутагт өндөр цалинтай ажлын байр бий болох боломжтой. Өөрөөр хэлбэл, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийн үндэс суурь бүрэлдэх жил нь 2022 он байх нь.

Манай улс гадаад худалдааны тал дээр хамгийн их чөдөр тушаатай улс. Дэлхийн банк группийн “Бизнес эрхлэх нь-2020” тайланд дурдсанаар манай улс тус байгууллагын гишүүн 190 орноос гадаад худалдааны үзүүлэлтээр 143-т жагссан төдийгүй энэ үзүүлэлтээр үргэлж сүүл мушгиж ирсэн. Шалтгаан нь дэд бүтцийн сул хөгжил юм. Харин энэ жил ашиглалтад орох төмөр замууд болон 2022 онд гараанаасаа хөдлөх дэд бүтцийн томоохон төслүүдийн ачаар эдийн засгийн урсгал эрчимжинэ гэсэн хүлээлт байна. ■

Ойрын таван жилийн хугацаанд төмөр замын салбарт 25 мянган мэргэжилтэн бэлтгэнэ.

Интернэт

Анхдагч байх амаргүй

Өнөөдөр интернэт багахан гацаж, технологийн бяцхан доголдол үүсэхэд л хүмүүс маш ихээр дургүйцэж, бухимдах болсон. Энэ нь ч зүй ёсны хэрэг. Учир нь хүн бүрийн ажил, амины бүхий л асуудал интернэтээр дамжин өрнөх болж, амьдралын хэв маяг урьд өмнөхөөс эрс өөрчлөгдсөн. Интернэт хэмээх “үл үзэгдэх” сүлжээ хоёрыг холбож, холыг ойртуулах болсноор эдийн засаг, нийгмийн харилцааг түүнгүйгээр төсөөлөх ямар ч боломжгүй болсныг энэ бүхэн илтгэж буй. Харин монголчуудыг дэлхийн хөгжилтэй эн зэрэгцэн алхаж, энэ бүх боломжийг хүртэх үүд хаалгыг “Датаком” компани 26 жилийн өмнө нээж, Монгол Улсыг 24 цагийн интернэт сүлжээнд холбосон юм. Үүний үр дүнд манай улс Ази тивээс интернэтэд холбогдсон 10 дахь улс болж, 1996 оны нэгдүгээр сарын 17 -ны өдөр түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн билээ.

“Датаком” бол Монголын интернэт үйлчилгээний анхдагч төдийгүй мэдээллийн технологийн олон дэвшилтэт технологи, шинэ үйлчилгээнүүдийг анхлан нэвтрүүлсэн туршлагатай компани. 1994 оноос хойш өнөөдрийг хүртэл тогтвортой, найдвартай, чанартай үйлчилгээг хэрэглэгч, харилцагчдадаа тасралтгүй хүргэж ирсэн тус компанийн удирдлагын баг байгууллагадаа 20 -иос дээш жил ажилласан мэргэжилтнүүдээс голдуу бүрддэгээрээ онцлог. Тэдний нэг нь “Датаком”-ын гүйцэтгэх захирал Г.Энхболд. Тэрбээр их сургуулиа төгссөн цагаас хойш энэ хамт олны нэг хэсэг болж, сүлжээний инженерээс гүйцэтгэх захирал хүртэл тасралтгүй 22 дахь жилдээ ажиллаж буй нэгэн. Түүнтэй өчигдөр, өнөөдөр, мөн ирээдүйн тухай товч ярилцлаа.

"Датаком" компани .МОН, .МN, ORG.MN домэйн нэрийн бүртгэл, удирдлага, вэбийн бусад үйлчилгээг албан байгууллага, хувь хүнд үзүүлдэг. Өдгөө 30 мянга гаруй домэйныг бүртгэж, үйлчилгээ үзүүлж буй. Харилцагчдадаа интернэт орчинд цогц үйл ажиллагаа явуулах, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг



Миний хувьд интернэтэд холбогдохоос илүү хэрхэн, яаж ажилладаг цаад бүтэц нь илүү сонирхолтой санагддаг байсан.

ашиглан виртуал ертөнцөд бизнесээ өргөжүүлэх боломжийг олгоход чиглэн ажилладаг. Түүнчлэн ICANN (International Corporation for Assigned Names and Numbers) олон улсын корпорацийн албан ёсны итгэмжлэлтэй, мөн Google компанийн албан ёсны төлөөлөгч.

8000 өдөр

Ойролцоогоор ийм хугацааг Г.Энхболд “Датаком”-д ажиллаж өнгөрүүлжээ. Багагүй хугацаа. Их сургуулиа дөнгөж төгссөн шинэхэн боловсон хүчин карьераа энд л эхлүүлж, өсөж хөгжиж, бас мэргэшжээ. Өөрөөр хэлбэл, Монголын мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцэн түүний карьер хөгжлийн түүх бичигдэж явсан ч гэж болно. Физикийн инженер мэргэжилтэй тэрбээр сонины хуудаснаас сүлжээний инженер ▶

► ажилд авах тухай зарыг олж харснаар “Датаком” компанитай анх холбогдсон түүхтэй. Хэдийгээр мэдээлэл технологийн чиглэлээр мэргэжил эзэмшээгүй ч “Энэ компанид л заавал ажиллана” гэсэн эрмэлзэл, хичээл зүтгэл нь өнөөдрийн түүнийг бүтээжээ. Нэг сонирхсон зүйлээ хэзээ ч хаядаггүй тууштай зан нь ч компанидаа 22 жил тогтвортой ажиллахад нөлөөлсөн юм. “Миний хувьд интернэтэд холбогдохоос илүү хэрхэн, яаж ажилладаг цаад бүтэц нь илүү сонирхолтой санагддаг байсан. Хоёр компьютерыг яаж холбоод байна гэдэг учир шалтгаан сониуч занг минь хөдөлгөсөн” хэмээн тэр дурсаж байна.

Хөгжих таатай орчин

1990-ээд оны сүүлч, 2000 оны эхээр Монголд мэдээлэл технологийн гарын авлага гэхээр ном, сурах бичиг байгаагүй учраас ихэвчлэн англи хэл дээрх эх сурвалжаас сурч, мэдэх их хэрэгцээгээ хангадаг байсан талаараа “Датаком” компанийн үе үеийн инженер, техникийн ажилтнууд ярьдаг. “Датаком”-ын үүсгэн байгуулагч Д.Энхбат ч тэднийг сайтар чиглүүлж, зөвлөнө. Одоогийнхоор бол “ментор” -лодог байв. Г.Энхболд ч тэдгээр суралцагчдын нэг байсан юм. “Амазон”-оос холбогдолтой номууд захиалж авчрахтай зэрэгцэн “Энийг унш, тэрийг харах хэрэгтэй” гэх зэргээр байнгын захиж, зөвлөж, цэнэглэж ирсэн нь салбараа өргөн далайцтай харах, олноос түрүүлж алхах, бусдын сэтгээгүйг сэтгэх орон зайг бүрдүүлж өгчээ.

Анхдагч байх амаргүй

Монголд интернэт нэвтрүүлснээ зарлахаар зэхэж байх үед Засгийн газар Д.Энхбатыг төрийн зөвшөөрөлгүйгээр барууны технологи нэвтрүүлсэн, Монголын нууцыг гадагшаа задруулах гэж байна гэсэн үндэслэлээр шүүхэд өгсөн тохиолдол ч бий. Монгол Улс интернэтэд холбогдсон 1996 онд интернэт хэрэглэгчдийн тоо ердөө 500 гаруйхан байв. Гар утас битгий хэл компьютертой хүн ч ховор байсан тухайн үед “Датаком” и-мэйлийн үйлчилгээгээр гараагаа эхлүүлж, удалгүй Мэйжикнэт ХХК, Ай Сервис ХХК, Нэткарт ХХК, Датанэт ХХК зэрэг охин компанийг байгуулан ажиллах болсон юм.

И-мэйл нээлгэх, и-мэйл болон факс илгээх, мэдээлэл хайх зэрэг нь бүхэл бүтэн үйлчилгээ

байсан гэхээр интернэт өдөр тутмын хэрэглээ болсон өнөө цаг үед сонирхолтой сонсогдож болох юм. Товчхондоо, өнөөдрийн хөгжлийг авчрах гол дэд бүтцийг “Датаком” компани хэн ч ойлгоогүй, сонирхоогүй, анзаараагүй, мөн дэмжээгүй байх үед бүтээн байгуулжээ. Цаг үеэсээ хэт түрүүлснээс, хэрэглэгчид бэлэн бус байснаас болж хойшлуулсан, зогсоосон, орхиоос аргагүйд хүрсэн төслүүд тэдний хувьд даанч олон байсныг ч тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээрийн нэг нь 2000 оны эхээр орон сууцны төлбөрийг урьдчилсан төлбөрт “Нэткарт”-аар дамжуулан төлөх үйлчилгээ байв. Шаардлагатай бүхий л дэд бүтэц, системийг угсарч хөгжүүлэн бэлэн болгосон ч хэрэглэгчид хараахан бэлэн болоогүй байсны зэрэгцээ суурь хөрс бүрэлдэж эхлэхэд ч хол байж. Харин энэ төрлийн үйлчилгээ хэдхэн жилийн өмнөөс бодит болж, зах зээлд амжилттай нэвтэрсэн зэргээс үзэхэд тэд үнэхээр түрүүлж алхаж байсан нь харагддаг. “Алдсан ч, оносон ч энэ бүхэн бидний хувьд хөгжилтэй, сургамжтай, гоё түүхүүд болон үлдсэн” хэмээн Г.Энхболд тодотгосон юм.

Зах зээлийн чиг хандлагыг мэдрэх нь

Технологийн хөгжлийн хурдыг гүйцэхэд улам төвөгтэй болж байгаа ч үүнээс хэрхэвч хоцорч болохгүй. Ялангуяа технологийн компаниуд. Зах зээлийн чиг хандлагыг мэдрэх, ямар шинэ үйлчилгээ нэвтрүүлбэл амжилттай нэвтрэх орон зай байгааг анзаарах зэргийг Г.Энхболд өөрийн мэдрэмжид тулгуурлан хийдэг. Үүний үр дүнд, юунд анхаарал хандуулж, хүний нөөцөө аль зүгт төвлөрүүлэх эсэхээ шийдэж чаддаг аж. Нэг газраа удаан зогсохоос аль болох зайлсхийж, үргэлж хөгжиж, өөрчлөгдөж байх нь орчин үеийн компаниудад зайлшгүй байх ёстой хэв маяг гэдгийг ч онцолж байв.

Өнөө цагт хэрэглэгчид хоорондын харилцааг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааг хялбарчилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдсэн. Тиймээс үүнтэй холбоотой шинэ үйлчилгээнүүд тэд нэвтрүүлж, дотоод системээ шинэчилснээр хүссэн үр дүндээ хүрч, өсөлтүүдийг үзүүлж, харилцагчийн тоогоо нэмж чаджээ. “Бид ингэж л тасралтгүй шинж чанараа хадгалж, уян хатан байдлаа сайжруулдаг” хэмээн тэр хэллээ. ■

Монголд интернэт нэвтрүүлснээ зарлахаар зэхэж байх үед Засгийн газар Д.Энхбатыг зөвшөөрөлгүй барууны технологи нэвтрүүлсэн гэсэн үндэслэлээр шүүхэд өгсөн тохиолдол ч бий.

Дижитал шилжилт

Шинэ цагийн цахим нүүдэлчид



Аль нэг кофе шопт зөөврийн компьютерийнхээ ард суугаа хүнийг хараад “онлайн ертөнцөөр аялж яваа биз” гэж бид боддог. Тэдний ихэнх нь өсөн нэмэгдэж буй нэгэн хөдөлгөөний төлөөлөл юм. Интернэттэй л бол кофе шоп, хостел, наран шарлагын газраас ч ажиллаж, бизнес эрхэлдэг digital nomads буюу цахим нүүдэлчид өдгөө тренд болж байна.

Хүмүүс зайнаас ажиллах болсноор томоохон компаниуд эрчим хүч цахилгаан, нийтийн хоолны урсгал зардлаа бууруулж жил бүр 1.7 тэрбум евро хэмнэдэг болов. “McKinsey”-ийн судалгаагаар оффисын ажилтнуудын 20 орчим хувь нь ажлын бүтээмжээ алдалгүйгээр долоо хоногт 3-5 өдөр албан тасалгаанаас гадуур ажиллах боломжтой аж. Ялангуяа дизайнер, сэтгүүлч, программист,

бизнесийн шинжээч нар онлайн ажлын горимд шилжиж, цахим нүүдэлчдийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн. Хүсэл мөрөөдлөөрөө “нүүдэлчин” болсон 35 сая гаруй хүн жил бүр 787 тэрбум ам.долларыг энэ амьдралын хэв маягтаа зарцуулж байна. Тэд тив дамнан аялж, цаг заваа зохицуулж, алсын хараагаа тэлэн шинэ танилуудтай болсоор.

Цахим нүүдэлчдийн анхдагч, АНУ-ын чөлөөт зохиолч, зөвлөх Стив Робертс 1983 онд 22 мянга гаруй километр замыг туулан эх орноороо аялжээ. Тэрбээр аяллынхаа хугацаанд ажлаа завсардалгүй бүтээлээ туурвисаар байсан юм. С.Робертс унадаг дугуйгаа нарны эрчим хүчээр цэнэглэдэг интернэт модем, байршил заагчаар тоногдсон байв. Харин Японы иргэн Цүгио Макимото “Дижитал нүүдэлчин” номоо 1997 онд хэвлүүлж, түүндээ ►

► “Арван жилийн дараа хүмүүс газарзүйн саад тогторыг анзаарахаа больж, ажлын эрх чөлөөг мэдэрнэ” гэж таамаглажээ.

Нэгэн цагт хачирхалтай мэт байсан энэ үзэл санаа эдүгээ бидэнд сонин санагдахаа больсон. 2030 онд манай гаргийн цахим нүүдэлчид нэг тэрбумд хүрнэ. Аюулгүй байдал, амьдралын өртөг бага улс, олны хөлөөс хол тав тухтай орчин руу тэд тэмүүлдэг. Зарим цахим нүүдэлчин тусгайлан тоноглогсон, зөөврийн байшин мэт автомашиндаа оффислож байна. Ийм нүүдэлчдийг ван лайферс буюу “фургонд амьдрагчид” гэж нэрлэдэг. Иймэрхүү дугуйтай албан тасалгаануудыг тохижуулахад 107 мянган ам.доллар шаардлагатай бөгөөд “BMW X7” автомашин зах зээлийн үнэ юм. Тиймээс автомашин үйлдвэрлэгч нар дижитал нүүдэлчдэд зориулсан явдаг оффисын төслүүдийг сонирхож, судалж эхэлжээ. “Ниссан” компани хотын хөдөлгөөнд тохиромжтой жижиг оврын фургоны загвараа танилцуулсан. “Caravan NV350” загвар бол ухаалаг гар утасны программ ашиглан өргөтгөх боломжтой оффисын зориулалтай фургон юм. Мөн “Мерседес” компани цахим нүүдэлчдэд зориулсан “VanTourer” микро автобус худалдаанд гаргажээ.

Шинэ үеийн нүүдлийн амьдралд анхаарах ёстой зүйлс бий. Цагийн зөрүүнээс шалтгаалж түншүүд болон үйлчлүүлэгчтэйгээ харилцахад бэрхшээлтэй тул ажил, амралтаа тэнцвэржүүлж, хуваарийг уян хатан боловсруулж, зохицуулах ёстой. Очсон орныхоо хууль дүрэм, онцлогийг мөн судална. Зарим оронд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хориглодог. Тухайлбал, “WhatsApp” апп-ыг АНЭУ-д хориглодог гэх мэт.

Монгол Улс дижитал нүүдэлчдийг татах боломжтой


Дэлхийн 20 гаруй улс татварын орлогоо нэмэх, дотоодын бизнесээ дэмжих хүрээнд ажил, аяллын энэ хэлбэрийг дэмждэг. Их Британийн “Travel Daily News” сэтгүүл дижитал нүүдэлчдэд ээлтэй, таатай нөхцөл санал болгодог 25 орныг эрэмбэлжээ. Жагсаалтыг утасгүй интернэтийн хамрах хүрээ, шатахууны үнэ, тээврийн хэрэгсэл, өдөр тутмын хоолны зардал, гэмт хэргийн гаралт, автозамын чанар, тэр байтугай хур тунадастай өдрүүд зэрэг үзүүлэлтийг харгалздаг байна. Энэ жагсаалтад манай улстай газар зүй, ►

Цахим нүүдэлчид ба Монгол Улс

★ Үнэлгээ	2.58/5 (Зэрэглэл №1220)
👍 Амьдралын чанарын оноо	OK
👤 Гэр бүлийн үнэлгээ	Тааруу
💰 Өртөг	Боломжийн үнэ: сард 1079 ам.доллар
🌐 Интернэт	Удаан: 2Mbps
👤 Хөгжилтэй байдал	Ok
🌡️ Агаарын хэм (одоо)	(-10°C)
🔋 Чийгшил (одоо)	Боломжийн 63%
👤 Агаарын чанар (одоо)	Зарим улсын үзүүлэлтээр эрүүл мэндэд хортой (АНУ-ын AQI 129)
👤 Агаарын чанар (жилд)	Сайн (АНУ-ын AQI 59)
👤 Аюулгүй байдал	Ok
👤 Гэмт хэргийн гаралт	Аюулгүй
👤 Боловсролын түвшин	Дунд зэргийн
👤 Орлогын түвшин	Маш бага: сард 307 ам.доллар
👤 Англи хэлний мэдлэг	Хангалтгүй
👤 Явган алхах боломж	Дээд зэргийн
👤 Амар амгалан байдал (цагдаагийн зөрчил)	Байхгүй
👤 Замын хөдөлгөөний аюулгүй байдал	Сайн
📶 Эрүүл мэнд	Сайн
😊 Аз жаргалын индекс	Тааруу
👤 Шөнийн амьдрал	Байхгүй
📶 Хот дотор үнэгүй WiFi	Сайн
👤 Ажиллах боломжтой газрууд	Олон
👤 Эйр кондишн/халаалт	Тааруу
👤 Гадаадын иргэдэд ээлтэй эсэх	Сайн ханддаг
👤 Үг хэлэх эрх чөлөө	Сайн
👤 Эмэгтэй хүнд ээлтэй байдал	Сайн
👤 LGBTQ+ хүмүүст нөхөрсөг эсэх	Мүү
👤 Старт-ап үнэлгээ	тааруу

Эх сурвалж: Nomadlist.com

Цахим нүүдэлчдэд хамгийн ээлтэй 25 улс

Эх сурвалж: traveldailynews.com

- уур амьсгалын төстэй нөхцөлтэй Казахстан улс багтжээ.

Дижитал нүүдэлчдийн дунд хамгийн эрэлттэй орон бол АНЭУ, Герман, Гүрж, Хорват, Чех, Португал. Мэдээж дижитал ажлын байрууд элбэг биш. Ажил олгогч нар долоо хоногийн тодорхой хэдэн өдөр оффист ажиллахыг шаарддаг. “Apple”, “Google” зайнаас ажилладаг ажилтнуудынхаа цалинг хасдаг аж. Гэхдээ энэ уян хатан байдал ковидын дараа шинэ амьдралын хэв маягийг эрэлхийлж буй дижитал ажиллах хүчийг татах боломж нээсэн.

Улс орнууд энэ чиг хандлагыг анзаарч, цахим нүүдэлчдийг татахаар өрсөлдөж эхэллээ. Итали улс тодорхой бүс нутагт суурьшигчдад жилийн хугацаанд 90 хүртэлх хувийн татварын хөнгөлөлт үзүүлдэг. Испанид хувиараа хөдөлмөр эрхлэх виз санал болгож байна. Түүнчлэн Эстонид очилгүйгээр тус улсад бизнес эрхэлдэг цахим оршин суугчид ч бий. Хорват, Норвег, Мальга, Гүрж, Дубай визийн хөнгөлөлтөөрөө дижитал нүүдэлчдийг соронз мэт татдаг. Норвег улс Хойд туйлын тойрог дахь алслагдсан Свалбард арал дээр амьдрах хүсэлтэй ажилчдад насан туршийн

виз олгодог.

Эдгээр орны нэгэн адил Монгол Улс цахим нүүдэлчдийг татах боломжтой. Тусгаар тогтносон улсуудаас хүн амын нягтаршил хамгийн бага, дэлхийд хосгүй жинхэнэ нүүдэлчин соёлтой ард түмэн. Тал хээрийн экосистемээс эхлээд жуулчдын анхаарал татдаг ландшафттай. Зуны улиралд аялахад хамгийн тохиромжтой, аюулгүй орнуудын нэг. Нэмж дурдахад, Монгол Улс коронавирусийн эсрэг вакцинжуулалтаар дэлхийд тэргүүлж байна. Хэрэв монголчууд Израилийн вакцинжуулалтын түвшинд хүрч чадвал Их Британийн “ногоон” жагсаалтад багтаж магадгүй. Улаанбаатараас Сөүл, Токио, Бээжин, Истанбул, Франкфурт, Москвагийн чиглэлд шууд нислэгтэй. Азид суурилсан дижитал ажил хийхэд хамгийн тохиромжтой цагийн бүсэд байрладаг.

Гэхдээ цахим нүүдэлчдийг татахыг хүсвэл Монголын Засгийн газарт шийдвэрлэх шаардлагатай архаг асуудал олон бий. Ил тод харагдаж байгаа бэрхшээл гэвэл Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаар дэлхийн хэвлэлүүд тогтмол мэдээлдэг. Зайлшгүй анхаарал хандуулах өөр нэг бэрхшээл бол цахилгааны сүлжээ. Мөн Монгол Улс интернэт тааруу хөгжсөн бөгөөд үүрэн сүлжээний хурдаар 112, суурин өргөн зурвасын хурдаар 85 дугаарт бичигддэг. Өвлийн тэсгим хүйтнээс халширсан дижитал нүүдэлчид Монголд жилийн турш амьдрах магадлал бага.

Засгийн газраас аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилго дэвшүүлсэн. Эрх баригчид ковидын дараах аялал жуулчлалыг сэргээх бүтээлч арга замыг эрэлхийлэх нь чухал. Монголын аялал жуулчлалын операторууд одоо тодорхойгүй байдалд байна. Тэд тахал дуусахыг хүлээх зуур өөр ажил хийж байгаа нь нууц биш. Зорилтот улс орнуудтай визгүй зорчих талаар хэлэлцээр хийх, визний зардлыг бууруулах, хугацаа сунгах, дижитал нүүдэлчдэд зориулсан визний шинэ ангиллыг нэвтрүүлэх зэрэг ухаалаг маркетинг нэвтрүүлбэл жуулчдыг татаж чадна. Гадны жуулчдыг, тэр дундаа ажлын байртайгаа ирдэг цахим нүүдэлчдийг татаж чадбал эдийн засагт л дэмтэй. ■

Үзэл бодол



Д.ГАН-ОЧИР, Монголбанкны
Ерөнхий эдийн засагч

Бид яагаад бэлэн мөнгөөр төлбөр хийдэг вэ

Мэдээллийн технологийн дэвшлийг санхүүгийн салбарт ашиглах болсон нь төв банкуудад цахим мөнгө гаргах боломжийг бүрдүүлсэн. Иймд төв банкууд цахим мөнгө гаргах асуудлыг 2016 оноос хойш эрчимтэй судлан ярилцаж байна. Ийм цахим мөнгө гарснаар бий болох ач тус, эрсдэлийн шинжилгээнд төв банкууд, эрдэмтэн судлаачид анхаарал хандуулах боллоо.


Санхүүгийн салбарт цахимжилт нэвтрэхийн хэрээр төлбөр тооцоон дахь бэлэн мөнгөний хэрэглээ буурч байна. Гэхдээ эдийн засаг тэлэхийн хэрээр гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний хэмжээ нэмэгдлээ. Тухайлбал, 2008 онд гүйлгээнд байсан бэлэн мөнгө нь нийт мөнгөний нийлүүлэлтийн 18 хувийг бүрдүүлсэн бол сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсаар 2021 оны эцэст дөрвөн хувь болсон. Харин эдийн засагт гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ сүүлийн 16 жилд тав дахин өсөж, 2021 оны эцсийн байдлаар 1.1 их наяд төгрөг болжээ (Зураг 1).

Банкуудын гаргасан картын тоо 2021 оны III улирлын байдлаар 4.3 сая ширхэг, үүнээс 2.1 сая картыг идэвхтэй ашиглаж байна. Банкууд зургаан төрлийн карт гаргаснаас Т карт 60 хувь, ЮнионПэй карт 23, Виза карт 14, Мастер карт гурав, Америкс карт 0.1, ЖэйСиБи карт 0.2 хувийг тус тус бүрдүүлдэг.

Төхөөрөмж тус бүрийн нийт төхөөрөмжийн тоонд эзэлж буй хувийг авч үзвэл ПОС машин 88.7, ПОБ 3.5, МПОС 2.5, АТМ 1.3 хувь, бусад хэрэгслүүд (CDM, CRM, цахим худалдаа, КИОСК) дөрвөн хувь байна. Төхөөрөмж дээр хийгдсэн нийт гүйлгээг бэлэн (ПОС, ПОБ, АТМ/CRM зарлага, CDM/CRM орлого), бэлэн бус (ПОС, МПОС, цахим худалдаа, АТМ/CRM, КИОСК (ПОС-той)) гэж ангилж үзэхэд бэлэн бус гүйлгээний тооны 88.6 хувь, гүйлгээний дүнгийн 62.1 хувийг бүрдүүлж байна (Зураг 2).


Улсын хэмжээнд нийт 3.1 сая интернэт

Зураг 1. Нийт мөнгөний нийлүүлэлтэд бэлэн мөнгөний эзлэх хувийн жин



Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн сарын бюллетень: 2021 оны 12-р сар"

Зураг 2. Бэлэн бус хэрэглээний гүйлгээний тоо, гүйлгээний дүн



Эх сурвалж: Монголбанк, "Төлбөрийн системийн тоон үзүүлэлт: 2021 оны III улирал"

банкны хандалтын эрх байгаагаас идэвхтэй ашиглаж байгаа (сард гурав ба түүнээс дээш удаа гүйлгээ хийдэг) 1.6 сая хэрэглэгч байна. Интернэт хандалтын гүйлгээний тооны 89.6 хувь нь гар утасны аппликэйшнээр, үлдсэн 10.4 хувь нь цахим хуудсаар хийгддэг ажээ. Харин 1.8 сая мобайл

- ▶ банкны хандалтын эрхтэй хэрэглэгчээс 526.3 мянга нь идэвхтэй ашиглаж байна.

Монгол Улсад цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч зургаан хувийн байгууллага (Ардкредит ББСБ ХК, Мобифинанс ББСБ ХХК, Супер апп хэтэвч ХХК, Инвескор хэтэвч ББСБ ХХК, Эм Пи Эс Си ББСБ, Хай пэймэнт солюшнс ХХК)-д нийт 11.9 тэрбум цахим мөнгийг нэг сая бүртгэлтэй хэрэглэгч төлбөр тооцоонд ашиглаж байна. 2021 оны III улиралд цахим мөнгөний үйлчилгээг ашиглан 278.8 цахим мөнгөний 3.8 сая ширхэг гүйлгээ хийгджээ.

Ирээдүйд төв банкны цахим мөнгийг төлбөр тооцоонд хэр идэвхтэй хэрэглэх вэ гэдгийг тандахын тулд хүмүүс яагаад бэлэн мөнгөөр төлбөрөө хийдэг болохыг сайтар ойлгох шаардлагатай.

Олон орныг хамарсан судалгаа, түүвэр судалгааны үр дүнгээс харахад хүмүүс бэлэн мөнгөөр төлбөр төлөхөд дараах хүчин зүйлс нөлөөлдөг байна²:

- Дадал зуришл;
- Мөнгөний үнэ цэнийг материаллаг хэлбэрээр төлбөр хийх үед илүү сайн ойлгох;
- Цахим төлбөрийн хэрэгсэлд нэвтрэх боломжийг хязгаарлаж буй саад бэрхшээл (хүүхэд, өндөр настангууд цахимаар төлбөр хийх боломжгүй эсвэл цахимаар төлөх хүсэлгүй);
- Төлбөр тооцоонд нэрээ нууцлахыг хүсэх;
- Нэмэлт шимтгэл, зардал байхгүй;
- Төлбөр тооцоо тухайн агишинд хийгдэнэ;
- Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээ, төлбөрийн төхөөрөмж, интернэт хангалтгүй;

Дээрхээс гадна хоёр талын нүүр тулсан төлбөр тооцоонд бэлэн мөнгө ашиглах нь хялбар байдаг. Дэлгүүрт бэлэн мөнгөөр төлбөр хийх нь дараах үндэслэлээр үргэлж эхний сонголт байдаг: 1) ихэнх дэлгүүр төлбөр тооцоонд бэлэн мөнгө хүлээн авсаар байна, 2) хүмүүс хэрэг болж магадгүй хэмээн бэлэн мөнгө авч явдаг. Энэ хоёр шалтгаан харилцан нэгнээсээ хамааралтай юм.

Бэлэн мөнгө нь албан ёсны төлбөрийн хэрэгсэл гэсэн статустай байхад төв банкнаас гаргасан мөнгөний шинж чанар нөлөөлдөг. Төлбөрийн хэрэгсэл нь бэлэн мөнгийг хүмүүс түгээмэл хэрэглэх, тэр хэрээр үнэ цэнээ хадгалах боломжийг олгодог. Хүмүүс бэлэн мөнгийг төв банкнаас гаргасан гэдэг үндэслэлээр төлбөр тооцоонд ашигладаг бус харин албан ёсны төлбөрийн хэрэгсэл гэдэг утгаар

хэрэглэдэг байж болно. Албан ёсны төлбөрийн хэрэгсэл болох энэхүү давуу эрх нь зөвхөн төв банкны мөнгө “дотор нь” байгаа хэрэгслүүдэд бий болдог. Үүний нэг жишээ нь, Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан хувийн хэвшлийн цахим мөнгө нь албан ёсны төлбөрийн хэрэгсэл тул дээр дурдсанчлан иргэд идэвхтэй ашиглаж буй явдал юм.

Мөнгөн тэмдэгтийн зардлын хувьд төв банкуудын мөрдөж буй нийтлэг зарчим бол мөнгөн тэмдэгт гаргаж, нэмэлт зардал шингээхгүйгээр тархаах явдал юм. Энэ зарчим нь төв банкууд хүүгүй өр төлбөрөө (гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө) хүүтэй активаас хэтрүүлэхгүй байж чадвал мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах нь ашигтай гэсэн таамаглалд үндэслэдэг. Бэлэн мөнгөтэй харьцах нь ямар ч тохиолдолд бүх талууд (төв банк, банкууд, иргэд, аж ахуйн нэгжүүд)-д зардалтай. Харин төв банк өөрийн цахим мөнгөний тусламжтайгаар цахим төлбөрийн хэрэгсэл гаргагчдын “орчин”-д ойртож, тус цахим мөнгийг гүйлгээнд гаргаж, түгээхэд тэдэнтэй хамтран ажиллах юм.

Нэгтгэн дүгнэхэд Монгол Улсад төв банкны цахим мөнгө гаргах хэрэгцээ, суурь орчин бүрдээд байна. Төв банкны цахим мөнгийг гүйлгээнд гаргахад технологийн шийдэл, түүний цахим аюулгүй байдлын шийдлээс гадна санхүүгийн системд үзүүлэх нөлөө, эхэндээ ямар тооцоонд ашиглах талаар нарийвчлан судлах шаардлага үүсэж байна. Үүний зэрэгцээ төв банкны цахим мөнгийг төлбөр тооцоонд амжилттай нэвтрэхэд шаардлагатай бэлтгэл (өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх байдал, цахим мөнгөний үр ашигтай, аюулгүй түгээлт, цахим мөнгөөр төлбөр хийх хэрэглэгчдийн эрэлт)-ийг хангах нь чухал боллоо. Эдгээр судалгаа, бэлтгэл ажлыг хангахад хугацаа шаардана.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2021 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдөр баталсан 91 дүгээр тогтоолын хавсралтын 3.1-д “Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ” гэсэн заалт орсон. Энэ хүрээнд төв банкны цахим мөнгө, түүнийг гаргахад анхаарах асуудлын талаар олон сонирхолтой судалгаа хийгдэхээр хүлээгдэж байна. ■

[1] Цахим мөнгө гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэн бүхий Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл юм.

[2] Bindseil, U, Panetta, F and Terol, I 2021, ‘Central Bank Digital Currency: functional scope, pricing and controls’, Occasional Paper Series, No 286/December 2021, European Central Bank.

ДЭЛХИЙ 2022 СЭТГҮҮЛ ХЭВЛЭГДЛЭЭ



ХУДАЛДААЛАХ ҮНЭ: 44.000₮ (хүргэлт үнэгүй)

ЗАХИАЛГА ӨГӨХ БОЛОН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: 7711-5477, 8010-0390, 9409-2904

Борлуулах байршил:

GOOD PRICE (Зайсан салбар)

Internom номын дэлгүүр (Төв салбар)

Номин (Билэг их дэлгүүр салбар)

Majestic Bookstore (Их дэлгүүр)

Цурманд орж буй

Коронавирусийг номхотгосны цаана нийтийн эрүүл мэндийн бүтэлгүйтлүүд нуугдаж байна гэж Эдвард Карр үзэв



Цар тахлууд үгүй болдоггүй харин бөхдөг. Ковид-19 ч 2022 онд тэгэх маягтай. Орон нутгийн болон улирлын чанартай дэгдэлтүүд ялангуяа вакцинжуулалт муутай, удаашралтай орнуудад гарах нь үнэн. Вакцины тогтоосон дархлааг давж гарах шинэ хувилбаруудыг тархвар судлаачид анхаарах хэрэгтэй. Гэсэн хэдий ч ковид нь томуу, энгийн ханиадтай адил эндемик болох хувь тавилантай эвлэрэх үед дэлхийн ихэнх хэсэгт амьдрал хэвийн байдалдаа, ядаж л тахлын дараах хэвийн байдалд орох төлөвтэй байна.

Эл хэгийн төлвийн цаана гайхалтай амжилт, дургүй хүргэм бүтэлгүйтлийн аль аль нь оршино. Амжилт юунд байна вэ гэвэл маш олон хүн вакцинжуулалтад хамрагдсан бөгөөд халдварын хөнгөн шинж тэмдгээс эрчимт эмчилгээ хүртэлх үе шат бүрт шинэ эмүүд нас барах эрсдэлийг эрс бууруулав. Үүнийг байх ёстой энгийн зүйл мэт хүлээж авч болох ч шинэ өвчний эсрэг маш олон вакцин, эмчилгээг хурдан бүтээж, лицензжүүлсэн нь шинжлэх ухааны ялалт юм.

Туршилтаас анхны лицензээ авах хүртэл полиемелитийн вакцин 20 жил зарцуулсан. 2021 оны эцсээр буюу SARS-COV-2-ийн анхны тохиолдол бүртгэгдсэнээс ердөө хоёр жилийн дараа сар тутам

Аймшигтай өндөр үнээр дархлаатай болов

ойролцоогоор 1.5 тэрбум тун ковидын эсрэг вакцин үйлдвэрлэгдэж байна. Амьдралын шинжлэх ухааны өгөгдлийн Airfinity компани 2022 оны зургадугаар сарын сүүлч гэхэд 25 тэрбум тун вакцин үйлдвэрлэсэн байх боломжтой гэж таамагласан. Есдүгээр сард болсон дээд хэмжээний уулзалтын үеэр ерөнхийлөгч Жо Байден нэг жилийн дотор дэлхийн хүн амын 70 хувийг вакцинд бүрэн хамруулахыг уриалав. Вакцины нийлүүлэлтийг хязгаарлах албагүй.

Вакцин бүрэн хамгаалалтыг хүмүүст, тэр дундаа ахмад настнуудад бий болгохгүй. Гэхдээ энэ тал дээр ч анагаахын шинжлэх ухаан сорилтыг давсан. Жишээлбэл, эхний шинж тэмдгүүдийг өдөрт хоёр удаа уудаг вирусийн эсрэг молнупиравир эмээр эмчилж болох бөгөөд туршилтаар нас баралт, эмнэлэгт хэвтэгсдийн тоог хоёр дахин бууруулсан байна. Нас барах эрсдэлийг 20-30 хувиар бууруулдаг хямд үнэтэй кортикостероид болох дексаметазоныг өвчин нь хүндэрсэн хүмүүс хэрэглэх боломжтой. Дундуур нь ремдевизир, Regeneron-ий үйлдвэрлэсэн эсрэг биетийн коктейл хэрэглэнэ.

Вакцинжуулалт, эмчилгээг хослуулах нь нас барах эрсдэлийг тодорхой хэмжээгээр хааж буй цуврал хана юм. Шинэ ханыг босгох бүрт ковидын хөнөөл багасна.

Гэвч амжилтын хажуугаар бүтэлгүйтэл бий. Ковид ирээдүйд бага хор хөнөөл учруулах өөр нэг шалтгаан бол өнгөрсөнд аль хэдийн ихийг хорлосонд оршиж буй. Маш олон хүн халдвар авчихсан учраас ковидын одоогийн хувилбаруудаас хамгаалагдаж байгаа. Мөн илүү олон хүн, ялангуяа хөгжиж буй орнуудын иргэд 2022 онд вакцин, эмийн хамгаалалтгүй хэвээр байна.

Энэхүү дархлаа аймшигтай өндөр үнээр олдсон. Энгийн жилтэй харьцуулахад ихэд тооцогдох цар тахлын үеийн нас баралтын тоог The Economist судалж үзэв. Аравдугаар сарын 22-нд манай үндсэн тооцооллын дагуу дэлхий даяар нийт 16.5 сая хүн нас барсан нь (10.2-19.2 сая хүртэлх хэлбэлзэлтэй) албан ёсны тооноос 3.3 дахин их байлаа. Нас барахад хүргэсэн халдварын хувийн талаарх таамаглалыг ашиглан тооцож үзвэл эдгээр нас баралт нь албан ёсны бүртгэлтээс 6-15 дахин их буюу 1.5-3.6 тэрбум халдварын үр дагавар байх магадлалтай юм. ►

► Их Британийн насанд хүрэгчдийн 93 хувь нь ирэх намар ковидын эсрэг биеттэй болохыг халдвар, вакцинжуулалтын хослол харуулж байна. Хүмүүс дахин халдвар авах эрсдэлтэйг Их Британийн жишээ харуулж байгаа ч вируст өртөх бүрт дархлааны систем нь түүнийг илүү сайн няцаадаг. Шинэ эмчилгээ, илүү олон залуус халдвар авч байгаа нь Их Британид нас баралтын түвшин өдгөө яагаад 2021 оны эхэн үеийн аравны нэгтэй тэнцэж байгааг тайлбарлаж байна. Бусад улс ч эндемик хүртэл ийм л замыг туулна.

Энэ бүхнийг аюултай шинэ хувилбар орвонгоор нь эргүүлж мэднэ. Вирус нь байнгын мутацид орж байгаа бөгөөд цар тахал удаан үргэлжлэх тусам шинэ хувилбар үүсэх өндөр магадлалтай. Хэдий тийм ч Омикрон, Ро хувилбарууд нь Дельтагаас бага үхлийн аюултай байж магадгүй. Нэмж дурдахад, одоогийн эмчилгээ үр дүнтэй хэвээр байхаас гадна вирусийн мутацид тааруулан вакциныг хурдан өөрчлөх боломжтой.

Зүгээр л нэг эндемик өвчин

Тиймээс өндөр настай, бие муутай хүмүүс, вакцин хийлгээгүй, эм тариа худалдан авах чадваргүй хүмүүс ковидоор нас барах нь нэмэгдэнэ. Заримдаа хүмүүс эрүүл мэндийн боловсролгүйн улмаас вакцин хийлгэхээс татгалздаг тул халдварт өртөмтгий хэвээр байдаг. Гэхдээ вакцины тунгуудыг баян улсууд нөөцөлж байгаа тул буурай, алслагдмал улсуудад вакцин олдох нь хэцүү байна. Хэдхэн долларын үнэтэй аюулгүй вакцин дутагдсаны улмаас амьжиргаа сүйрч, хүмүүсийн амь үрэгдэх болно.

Ковид одоохондоо дуусаагүй байна. Гэхдээ 2023 он гэхэд хөгжилтэй орнуудын ихэнх хүмүүсийн хувьд энэ нь үхлийн аюулт өвчин байхаа больно. Харин олон тэрбум ядуусын хувьд үхлийн аюул болсоор байна. Харамсалтай нь бусад өвчний хувьд ч ийм л байх нь үнэн. Ковид зүгээр л нэг өвчин болох замдаа орсон. ■

ЭДВАРД КАРР, Орлогч эрхлэгч, The Economist

Хэдхэн долларын үнэтэй аюулгүй вакцин дутагдсаны улмаас амьжиргаа сүйрч, хүмүүсийн амь үрэгдэх болно.

Дэлхий 2022 онд САНХҮҮ булан

Эргэж ирсэн, гэхдээ удахгүй



Энэ ч бас дуусна

Инфляцын тухай санаа зовних нь багасна

Цар тахлын урдах жилүүдэд инфляцад санаа зовох нь трапец өмд, тугалгатай бензин шиг л моодноос гарсан асуудал байв. Гэвч дэлхийн эдийн засаг Ковид-19-ийн хямралаас эргэж сэргэхэд хуучин гамшиг дахин ирэв. Инфляц Америкт таван хувь, Англид гурван хувь давж, шинээр хөгжиж буй олон улсад үүнээс өндөр хэмжээнд хүрчээ. 1970-аад оны өндөр инфляц удахгүй эргэн ирнэ гэж зарим эдийн засагч анхааруулж байна. 2022 онд ийм айдсууд арилах боловч төв банкныхан наана нь хөлсөө багагүй урсгана.

1980-аад оноос 2020 оныг хүртэл дэлхий даяар инфляц алгуурхан буурч байв. Эл бууралт нь төв банкууд үнийн дарамтыг хяналтад авахдаа ихээхэн туршлагажсаны илрэл байснаас гадна бүтцийн хэд хэдэн өөрчлөлт уг үйл явцыг хөнгөвчилжээ. Даяарчлалын нөлөөгөөр ►

► үйлдвэрлэлийн зардал болон ажилчдын цалингаа нэмэгдүүлэх шаардлага буурснаар цалингийн өсөлт хумигдсан. Түүнчлэн дэлхийн чинээлэг хүн амын тоо хөгширснөөр хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, энэ нь өмнөх үе шиг орлого өсөхийн хэрээр хэрэглээ өсөхгүй байгааг харуулав. Дэлхийн санхүүгийн хямралын дараа инфляц төв банкуудын зорилтот түвшнээс доогуур байсан бөгөөд энэ нь Америкийн Холбооны нөөцийн банк зэрэг төв банкуудад инфляцыг нэмэгдүүлэх эрх чөлөөг олгосон. Энэ нь түрэмгий рефлексстэй эдгээр байгууллагын хувьд эрс өөр дүр зураг байв.


Тэгтэл Ковид-19 довтлов. Санхүүгийн зах зээлийг дэмжихийн тулд төв банкууд санхүүгийн системд асар их мөнгө цутгалаа. Засгийн газрууд Дэлхийн II дайнаас хойш байгаагүй их хэмжээгээр зээл авч, хөдөлмөр эрхлэх чадваргүй хүмүүсийн орлогыг дэмжсэн. Америкийн Засгийн газрын төсвийн алдагдал 2020, 2021 онд ДНБ-ий 12 хувиас давав.

Эдийн засагт их хэмжээгээр мөнгө цутгасны хүчинд эрэлт буурахаас сэргийлсэн ч нийлүүлэлтийн хувьд байдал өөр. Ковид-19 бүх төрлийн бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийг тасалдуулсан. Ган, хэт халуун нь кофе, улаан буудай зэрэг үр тарианы ургацыг бууруулав. Түүнчлэн дэлхийн тээвэрт тулгарсан бэрхшээл нь ачаа тээвэрлэлтийн айхтар гацааг үүсгэлээ. Түлшний хүрэлцээ сулаас шалтгаалж өвөл дөхөхөд нүүрс, байгалийн хий, газрын тосны үнэ огцом өссөнөөр 1970-аад оны эрчим хүчний шокийг эргэн сануулав.

Ийм дарамтын үед Харвардын их сургуулийн Ларри Саммерс зэрэг эдийн засагч инфляцын шинэ эриний анхны шинж тэмдгүүдийг олж харжээ. Нээлттэй ажлын байрыг нөхөхийн төлөө компаниуд хичээж буй нь сул ажиллах хүчний эрин дуусаж буйг илтгэж байна. Нэг үеэ бодвол төв банкууд ажилгүйдлийн түвшнийг бууруулахад илүү анхаарч, инфляцын эрсдэлд тайван хандаж байна. Инфляц өөрийгөө бий болгох чадалтай. Хүмүүс өндөр хэмжээтэй, байнгын үнийн өсөлтөд дасах тусам үнээ өсгөх нь өмнөх шиг тийм ч муу зүйл биш болсныг бизнесүүд анзаардаг. Эдийн засагчдын хэлж буйгаар инфляцын хүлээлт тодорхойгүй болж мэднэ. Эрчим хүчний зардал нэмэгдэх нь эдийн засгийн өсөлт, бүтээмжийг бууруулж болзошгүй.

Өссөөр

Хэрэглээний үнэ, өмнөх жилтэй харьцуулсан өсөлт, хувиар



Эх сурвалж: Haver Analytics

2022 онд дэлхийн ихэнх оронд бодлогын хүү өснө. Инфляц эргэж ирсэн, гэхдээ удахгүй.

2022 онд инфляц төв банкны зорилтот түвшнээс давсан хэвээр байх боловч 2021 оны түвшнээс буурах тул макро эдийн засгийн нэн чухал асуудал байхаа болино. Хавар эрчим хүчний эрэлт буурах, түлшний үйлдвэрлэл нэмэгдэх, магадгүй Хятадын эдийн засаг удаашрахтай холбоотойгоор эрчим хүчний үнэ буурч, тогтворжих хүлээлттэй байна. Тээвэрлэлтийн асуудлыг шийдэхэд их хугацаа шаардах болов уу. Засгийн газрууд эдийн засагтаа их хэмжээний мөнгө цутгааа зогсоож, тэтгэмжүүдийг бууруулж буй тул эрчим хүчний өндөр төлбөр өрхийн санхүүд дарамт болж магадгүй. Вакцинжуулалт нэмэгдсэнээр олон хүн хөдөлмөрийн зах зээлд нэгдэж, хэрэглээний зарцуулалт үйлчилгээний сектор руу шилжсэнээр барааны хомсдолыг арилгахад туслана.

Хамгийн гол нь цар тахлаас өмнө инфляцыг хазаарлаж байсан олон хүчин зүйл хэвээрээ байна. Тухайлбал, хүчирхэг үйлдвэрчний эвлэлүүд эргэн сэргэхгүй, хүн амын хөгшрөлт үргэлжилсээр байна, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд гарч буй хүндрэлээс үл шалтгаалан даяарчлалд ухралт гарах шинж тэмдэг ажиглагдахгүй байна. Төв банкууд ч инфляцыг хэрхэн дарахаа мартаагүй. 2022 онд дэлхийн ихэнх оронд бодлогын хүү өснө. Инфляц эргэж ирсэн, гэхдээ удахгүй. ■

ЭДВАРД КАРР, Орлогч эрхлэгч, The Economist

Дэлхий 2022 онд УРЛАГ булан

Стримингийн дайн

Энтертайнмент тулааны талбар Европ, Ази руу шилжинэ



Далайн амьтны зураг авч байна

Ковид 19-ийн улмаас найруулагчид “Стоп” гэж хашхирхаас өөр аргагүй болсны дараа 2021 онд телевизийн шинэ цуврал ховордов. Гэхдээ зураг авалт эргэн сэргэснээр 2022 он үзэгчдийг уйдаахгүй. Дэлхийн тэргүүлэх видеостример Netflix шинжлэх ухааны зөгнөлт “Stranger Things” хит цувралын дөрөвдүгээр улирлыг гаргана. Amazon компанийн энтертайнмент нэгж Prime Video хагас тэрбум долларын төсөвтэй “Бөгжний эзэн” цувралын үргэлжлэлийг танилцуулна.

Дээрх цувралууд үзэгчдийн нүдний төлөөх “стриминг дайн”-ы нэг хэсэг бөгөөд эл тулаанд Холливуд, Цахиурын хөндийн энтертайнмент ачулууд бие биеэсээ илүү их хөрөнгө зарцуулан өрсөлдөж байна. Гэхдээ ихэнх улсад энэ “дайн” хоёр гурван оролцогчоор хязгаарлагддаг. Netflix, Amazon хаа сайгүй. Apple TV 100 гаруй оронд байдаг. Бусад нь дөнгөж хөгжиж буй жижгүүд.

Холливудын бусад стримерүүд шинэ зах зээлүүдэд нэвтрэх учир 2022 онд байдал өөрчлөгдөнө. Олон улсад тэлснээр тэд хэдэн арван сая шинэ хэрэглэгчтэй болж, дайны богцоо дүүргэх боломжтой болно. Харин хэрэглэгчдийн төлөөх тулаан дотоодод байдгаас илүү ширүүснэ.

Холливудын хамгийн том студи Дисней Азид бүр гүнзгий нэвтэрч, Дисней+ үйлчилгээг Хонконг, Тайвань, Солонгост (Netflix-ийн 2021 оны супер

Зарим улсад стриминг дайн стриминг компаниудын нэгдлээр солигдож байна

хит “Squid Game” цувралыг авсан улс) нээв. Comcast Cable вант улсын нэг хэсэг NBC-Universal-ийн Peacock стриминг платформ, WarnerMedia-ийн HBO Max Европт нэвтрэх ажлаа эхлүүлсэн. Баримтаг бүтээлийн Discovery+ саяхан Бразил, Канад, Филиппинд салбараа байгуулжээ.

Энэ жил тэлэлт улам эрчимжинэ. Disney+ Зүүн Европ, Ойрхи Дорнод, Африкт үйл ажиллагаагаа эхлүүлэх бол ViacomCBS-ийн эзэмшдэг Paramount+ Европын том том зах зээлүүдийг онилжээ. “Game of Thrones”, “Succession” зэрэг Америкийн алдарт цувралуудыг бүтээсэн HBO Max Европ дахь байр сууриа улам батжуулна.

Холливудын хувьд гадаад үзэгчид хатуу самар байна. Шинэ зах зээл орлого багатай: Disney+ Энэтхэгийн хэрэглэгчдээс сард нэг хүрэхгүй долларын ашиг олдог. Чинээлэг орнууд хүртэл Америкаас бага төсөвтэй. Америкт кабелийн дундаж төлбөр сарын 100 орчим доллар байдаг гэж судалгааны Ampere Analysis компани тооцоолсон. Англид үүний хагастай тэнцэх төлбөртэй. Улам олон америк хүн өндөр үнэтэй кабелийн багцаасаа татгалзаж, стриминг үйлчилгээг сонгож байхад европчууд телевизийн төлбөрт сувгаа сонгосоор.

Лицензийн тухай асуудлыг хөндөх ёстой. Дисней тэргүүтэй зарим студи бүх кино, шоугаа зөвхөн өөрсдийн стриминг үйлчилгээнд байршуулдаг. Бусад нь янз бүрийн дистрибьютеруудын өмнө лицензийн хариуцлага хүлээсэн хэвээр. HBO Max гэхэд Англи зэрэг Европын том орнуудад нээлтээ хийх өдрөө удахгүй зарлана. Гэтэл хамгийн алдартай нэвтрүүлгүүдийн Европ дахь эрхийг Comcast-ийн Sky компани эзэмшдэг.

Эдгээр зах зээлд нэвтрэхэд хэцүү байдгийн нэг шалтгаан нь стриминг дайн стриминг компаниудын нэгдлээр солигдож байгаа явдал юм. Discovery, WarnerMedia хоёр Netflix-тэй өрсөлдөхийн тулд 2022 онд нэгдэхээр төлөвлөжээ. Peacock мөн Paramount+ хоёрыг эзэмшдэг Comcast, ViacomCBS олон улсад хамтран ажиллахаар тохиролцсон. 2022 онд маш олон бүтээл дэлгэцэнд гарна. Хамгийн гол нь юуг, ямар платформ дээр үзэх вэ гэдгээ сонгох л хэцүү байна. ■

Дэлхий 2022 онд МОНГОЛ булан

Шинэ загвар, шинэ сэргэлт, шинэ гүрэн



Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн ачаар хүн амын төвлөрөл, тэгш бус хөгжлийг шийдвэрлэх боломжийг нээж өгсөн гэж УИХ-ын дарга Г.Занданшатар хэллээ.

Монголын ард түмний илгээлт, итгэлээр байгуулагдсан энэ удаагийн парламент сүүлийн 20 гаруй жил идэвхтэй яригдсан ч үр дүнд хүрч чадаагүй байсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг бодит үйл хэрэг болгож чадсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлдэх үйл явдал байлаа. Эх орноо хөгжлийн замд нь хөтөлж, эрх зүйн хувьсгалыг эхлүүлсэн нэмэлт өөрчлөлтийг Улсын Их Хурал таван сарын турш тасралтгүй хэлэлцэхдээ нийгмийн зөвшилцлийг хангах үүднээс төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн намууд, эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 600 гаруй саналыг нухацтай авч үзсэн билээ.

Ийнхүү түүхэн нэмэлт өөрчлөлтийг хийснээр төр тогтвортой, засаглал нь тэнцвэртэй, шүүх нь хараат бус, нутгийн удирдлагын тогтолцоо нь зөв болж, төр цэгцрэх үндэс тавигдаж байна. Үүнийг

Төр тогтвортой, засаглал нь тэнцвэртэй, шүүх нь хараат бус, нутгийн удирдлагын тогтолцоо нь зөв болж, төр цэгцрэх үндэс тавигдаж байна.

дагаад Шүүхийн тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай зэрэг холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт орсноор сүүлийн 30 жилийн турш монголчуудын хөгжлийг тушиж байсан саад даваа арилан зөвхөн хууль засагласан сонгодог парламент бүхий улсыг бүтээн байгуулах үндэс суурь тавигдаж байна. Энэ бол эх орноо эмхлэн цэгцэлж, өөрчлөн зохион байгуулах их үйлсийг өнгөн төдий нүд хуурсан байдлаар бус ул сууринаас нь эхлүүлж буйн илрэл юм.

Холын мэт сонсогдох болсон ч ойрын ирээдүйд авч ирэх хөгжил дэвшлээ бид чухам хэрхэн чиглүүлэн залах вэ гэдэг асуудлыг маш нухацтай ярилцах ёстой. Өөрөөр хэлбэл, хөлгүй далайд залуургүй хөвөх хөлөг онгоц мэт зорьсон газраа үл хүрэх эрсдэл бий гэдгийг эртнээс хэлж буй хэрэг. Энэ ч утгаараа хөгжлийн луужингаа дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр дэлхийд гуравт бичигддэг, үсрэнгүй хөгжлийн үлгэр жишээ болсон Япон улсын зүг чиглүүлж, “Япон лугаа адил хөгжье” гэсэн уриалга дэвшүүлэн ажиллаж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын сайн түнш Наран улсын хөгжлийн замыг мөр алгасалгүй сохроор дагахын нэрийдэл биш юм. Харин Япон хэв загварыг Монголынхоо онцлог байдалд нийцүүлэн нутагшуулж, хөгжилд хүрсэн бодит туршлага, сайн загвар, даван туулсан бэрхшээлүүдээс нь суралцах замаар өөрийн гэсэн хөгжлийн загварыг бий болгох явдал билээ.

Иргэн баян бол улс баян гэдэгчлэн Монгол онцлогтоо тохирсон хөгжлийн загвараар явж чадвал бид цалин орлого, амьдралын чанар, боловсролын түвшингээрээ дэлхийн бусад хөгжингүй орнуудтай өрсөлдөхүйц хүчирхэг дундаж давхаргыг бий болгоно. Үүний тулд бусад олон төрлийн зохицуулалтыг хийх шаардлагатай нь ойлгомжтой юм. Эдгээрийн нэг нь яах аргагүй хөгжлийн бодлогын асуудал билээ.

Өнгөрсөн хугацаанд УИХ-аар баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь үндэслэл, суурь шинжилгээ, уялдаа холбоо, төлөвлөлт дутуугийн улмаас “амьгүй” болох нь элбэг ▶

► байсан. Иймд аливаа хөгжлийн баримт бичгийг амь оруулан албажуулж, залгамж чанарыг нь хангуулахад хэзээ нэгийг холбогдолөгч, долоон бүлэг 25 зүйл бүхий Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг УИХ-аас хэлэлцэн батлаад байна. Ингэснээр үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлж, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлж өгсөн юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн залгамж чанарыг сайжруулж байгаа нь нөгөө талдаа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улс хууль эрх зүйн орчин нь тогтвортой, ирээдүйн чиг баримжаа нь тодорхой, итгэл даах, эдийн засаг санхүүгийн боломжоор дүүрэн орон болохыг харуулах юм.

Хөгжлийн чөдрийг мулталсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт нутгийн удирдлагыг боловсронгуй болгох эрх зүйн шинэчлэлийг хийсэн нь хурцадмал түвшиндээ хүрээд буй хүн

амын төвлөрөл, түгжрэл, иргэндээ ээлгүй хот төлөвлөлт, газар зүйн байршлаас шалтгаалсан тэгш бус хөгжлийг шийдвэрлэх боломжийг нээж өгсөн.

Эдийн засгийн бие даасан, хараат бус байдал нэн тэргүүнд тавигдах болсон энэ цаг үед УИХ-аас Шинэ сэргэлтийн бодлогыг цаг алдалгүй баталсан нь коронавирусийн цар тахлын улмаас иргэдийн нуруун дээр ирсэн ачаанаас хөнгөлж, цаашлаад “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм. Боомтын сэргэлт, Эрчим хүчний сэргэлт, Аж үйлдвэржилтийн сэргэлт, Хот, хөдөөгийн сэргэлт, Ногоон хөгжлийн сэргэлт, Төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн зургаан бүлэгт хамаарах 29 зорилтыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн голлох салбаруудад тулгамдаад буй асуудлууд шийдвэрлэгдэх болно. Харин цаашдын ирээдүйд эдийн засгийн өсөлт дунджаар зургаан хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого хоёр дахин нэмэгдэх зэрэг эерэг хүлээлт байгаа нь шинэ загвараар сэргэн мандсан хүчирхэг гүрэн болох итгэлийг түмэн олонд түгээж байна. ■

Эдийн засгийн өсөлт дунджаар зургаан хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого хоёр дахин нэмэгдэнэ

Дэлхий 2022 онд МОНГОЛ булан

Үйлдвэрлэгч улс болъё

Үйлдвэрлэгч улс болсноор нийлүүлэлтийн гаралтай инфляцын өсөлтийг удирдаж чадна гэж Монполимет группийн ТУЗ-ийн дарга Н.Мөнхнасан онцоллоо.

Өнгөрсөн хоёр жилийн цар тахлын сорилт манай бизнесийн салбарынханд томоохон шалгуур болж, дэлхий дахинаа том сургамж үлдээлээ. Харин одоо энэ хүнд үеийн сургамжид түшиглэн хөгжих цаг ирж байна. Дэлхийн эдийн засаг 2022 онд цар тахлын хүнд үеэс харьцангуй өндөр буюу 4.1 хувиар өснө гэсэн таамаглалтай байна. Гэхдээ улс орнуудын ►



Аливаа том төсөл ардаа олон зуун жижиг, дунд үйлдвэрийг тэтгэж явдаг эдийн засгийн хуультай

▶ хувьд харилцан адилгүй дүр зурагтай байгаа нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотой.

Олон улсад бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээ алдагдаж, үнийн өсөлт эрчимжсэн өнгөрсөн оны нөхцөл байдал 2022 онд тийм ч амархан намжихгүй. Ялангуяа, хил гааль, логистикийн асуудал энэ жилийн хувьд гол гогцоо нь хэвээр байна. Үүнийг цар тахалтай холбож дүгнэж байгаа хэдий ч цаашид давтагдахгүй гэсэн баталгаа байхгүй. Гэхдээ бэрхшээл бүрийн ард боломж байдаг. Бид боломжийнхоо хэрээр дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, тодорхой хэмжээнд үйлдвэрлэгч орон болж байж энэ хамаарлыг бууруулна.

Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан аж үйлдвэрийн сэргэлтийг бий болгож чадвал, Монгол Улс ганц боомтоос хараат байдлаа халах боломж бий. Гэхдээ тухайн улс оронд нэн шаардлагатай, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл рүү бодлогоо чиглүүлэх ёстой. Мөн бүх зүйлийг дотооддоо үйлдвэрлэнэ гэж үгүй. Гагцхүү өөрсдийн нэн тэргүүнд хөгжүүлэхээр зорьж буй салбарууддаа хөрөнгө оруулалтаа ач холбогдлоор нь эрэмбэлэн оруулах, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн тодорхойгүй, эсвэл хэрэгждэггүй заалтуудыг засах шаардлага байсаар байна. Өнөөдөр дотоодын олон хөрөнгө оруулагч энэ хуулиас болж хохироод байна.

Манай улсын эдийн засаг ерөнхийдөө өсөлтийн цикльдээ эргэн орох магадлал давамгайлж байгаа нь уул уурхайн түүхий эдийн үнийн өсөлт, төсөв, мөнгөний тэлсэн бодлоготой холбоотой. Тэр дундаа зөв менежментээр ханшийн өндөр үеийг ашиглаж чадвал уул уурхайн салбараас өндөр үр өгөөж хүртэх боломж бий. Нөгөө талдаа төсөв, мөнгөний тэлсэн бодлого үргэлжилбэл үнийн өсөлтийг өдөөх учир инфляцыг бууруулах арга хэмжээ тогтмол авах шаардлага үүсэж байна.

Эдийн засаг өсөж буй нөхцөлд үнийн өсөлт, эсвэл валютын ханшийн хэлбэлзэл тодорхой хэмжээгээр явагдана. Эдийн засаг, инфляц болон валютын ханшийн өсөлтийг жигд барих “боломжгүй гурвалжин” гэж тодорхойлдог ч эдийн засаг өсөхийн хэрээр иргэдийн цалин, банкны хадгаламжийн хүү үнийн өсөлтөө давж байх учиртай. Эцэстээ өнөөгийнх шиг нийлүүлэлтийн гаралтай инфляцын өсөлтийг

бид өөрсдөө үйлдвэрлэгч улс болсноор удирдаж чадна. Үйлдвэрлэлээр дамжуулан импортын үнийн өсөлтийг халж чадсан нөхцөлд эдийн засаг тогтвортой өсөн тэлэх, ядуурал дагасан утаа багасах, халамжийн бус ажилтай орлоготой улс орон болох нь эргэлзээгүй.

Манай улсын хувьд, бодлогын хүү буурч, инфляц өссөнөөр бодит хүү хасах утгатай болоод удаж байна. Энэ нь гол нэрийн импортын бүтээгдэхүүний тээвэр логистик болон цар тахлын хүндрэлүүдээс үүдсэн онцлогтой ч ард иргэдийн амьжиргааг дордуулах хамгийн том хүчин зүйл болж буй. Тэр дундаа, хамгийн их нэрвэгддэг бүлэг бол ядуурлын түвшинд байгаа 903.4 мянган иргэний амьдрал ахуй юм. Аливаа улсын хөгжлийн чанар буюу амьжиргааны түвшний ялгааг хэмждэг Gini коэффициент Монгол Улсын хувьд өссөөр байгааг бид илүү анхаарах ёстой.

“Монполимет групп” 2022 онд “Монцемент” брэнддээ төвлөрч, улс орны нэн шаардлагатай байгаа бүтээн байгуулалт, төслүүдэд хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна. Манай хамт олон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, судалгаа, цемент дээр суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулалтын сувгаа нэмэгдүүлэн улс орныхоо хөгжил цэцэглэлтэд бодит хувь нэмэр оруулах зорилт дэвшүүлсэн.

Аливаа том төсөл ардаа олон зуун жижиг, дунд үйлдвэрийг тэтгэж явдаг эдийн засгийн хуультай. Улсынхаа төсөв хөрөнгийг бүрдүүлдэг томоохон аж ахуйн нэгжүүд харьцангуй давуу талаа нэгтгэн хамтарч чаддаг болчихвол бүр ч илүү үр бүтээлтэй ажиллах юм шиг санагддаг. Хувь хүнийхээ хувьд шинээр төрөн гарч буй 10 гаруй төсөлд, нийгмийн төрөл бүрийн салбаруудад хөрөнгө оруулалт хийсэн. Зарим төсөл нь мэдээллийн технологийн төсөл бөгөөд хамгийн сонирхолтой нь энэ салбар аливаа хил гааль, тээвэр логистикийн асуудлаас хамаарал бага тул манайд заавал хөгжих шаардлагатай чухал салбар юм.

Эдгээр төсөлдөө хөрөнгө оруулалт хийгээд зогсохгүй аль болох цар хүрээг нь томруулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг нь таниулахад зөвлөж ажиллана. Гол нь эндээс үндэсний үйлдвэрлэлийг бага ч болов хөгжүүлэх, дэлгэрүүлэх зорилго тээн ажиллаж байна. ■

Зочин

Д.Цэрэнбат: Монголынхоо төлөө өөрийн чадах хэмжээндээ зүгээр суухгүй байх бодол бий



“Цахим өртөө холбоо” ТББ-ыг үүсгэн байгуулалцаж, хилийн чанадад 20 гаруй жил ажиллаж амьдарч буй “Тогтвортой ноос ноолуурын эвсэл” олон улсын байгууллагын олон нийттэй харилцах албаны менежер Д.Цэрэнбаттай ярилцлаа.

-Таныг “Цахим өртөө” сүлжээ, “Цахим өртөө” холбоо ТББ-ын Д.Цэрэнбат гэдгээр нь хүмүүс мэддэг. Та өөрийгөө манай уншигчдад танилцуулна уу?

-Би Төв аймгийн Батсүмбэр суманд төрж, Алтанбулагт өссөн. МУИС-ийг математикч, статистикч мэргэжлээр төгсөөд 1997 он хүртэл Удирдлагын академид багшилж байсан. 2001 онд Английн Кингстоны их сургуульд эдийн засаг, бизнесийн прогнозчлолоор магистрын зэрэг хамгаалж, 2003 оноос хойш Английн “Custom network” LTD компанид санхүүгийн менежерээр, 2018 оноос “Тогтвортой ноос ноолуурын эвсэл” олон улсын байгууллагад олон нийттэй харилцах

Өдгөө олон улсын болон дотоодын 100 гаруй брэнд, ноолуурын үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа компани гишүүнээр элсээд байна.

албанд давхар ажиллаж байна. Сүүлийн 24 жил Англи улсад ажиллаж амьдарч байна даа.

–“Цахим өртөө” сүлжээг анх яагаад байгуулах болсон бэ? Сүүлийн үед ямар онцлог төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэв?

-Цахим Өртөөний талаар олон ярьж байсан болохоор товчхон мэдээлэл өгье. Гадаадад байгаа монголчууд эх орноо гэсэн сэтгэлээр оргилж явдаг, тэр хүсэл тэмүүллийг нь нэгтгэх, цахим талбар бий болгохоор Цахим Өртөө үүссэн. Монголын талаар мэдээлэл авах цахим хуудас ховор цаг үе байсан. Мэдээллээр цангасан монголчуудын дунд Цахим Өртөө сүлжээ хурдан тархсан нь цаг үеийн онцлог байж. Тухайн үедээ олон зүйл санаачилж хийж байлаа. Харин одоо сайн дурын бүлгэм маягтай үйл ажиллагаа явуулж буй. Цахим Өртөө холбоо гэж байгуулагдсан тэр шугамаараа цөөнгүй ажил хийж байна. Үүний нэг нь манай Д.Сайнбаярын санаачилсан Монгол туургатан залуусыг ивээн тэтгэж сургах хөтөлбөр. Хилийн чанадад хүрч ажиллах анхны санаа сэдлийг өдгөө Хилийн чанд дахь монголчуудын зөвлөл (ХЧМЗ) үргэлжлүүлээд хийж байна.

-Та бол Тогтвортой ноос ноолуур эвслийг идэвхтэй дэмжин, гадаад харилцааг нь хариуцаж ажилладаг. Тийм болохоор эвслийн үйл ажиллагааны талаар яриагаа үргэлжлүүлэе гэж бодож байна.

-Хөдөө мал ахуйтай ойр өссөн болохоор малчдынхаа амьдралд тустай зүйл хийхсэн гэдэг бодол байнга сэтгэлдээ тээж явдаг. 2018 оноос Тогтвортой ноос ноолуурын эвсэлд (ТННЭ) өөрийн боломжоороо тусалж дэмжээд олон нийттэй харилцах албаны менежерээр ажиллаж байна. Энэ бол хилийн чанадад суугаа монголчуудын үүсгэн байгуулсан байгууллага гэдгээрээ онцлог. Нөгөө талаар Британид бүртгэгдсэн, ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулдаг гадны олон брэнд, компанийг гишүүнээр ▶

“ISEAL”
олон улсын
байгууллагад
элссэн нь Монгол
ноолуур барууны
зах зээлд гарах
гол шалгуурыг
хангасан

▶ элсүүлэн ажиллаж байгаа олон улсын байгууллага. Олон улсын түвшинд худалдаа эрхлэх чадамжийг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдэхэд чиглэсэн олон үе шаттай зорилго, зорилтуудыг дэвшүүлээд ажиллаж байна. Барууны хэрэглэгчид, үйлдвэрлэгчдийн хүсээд байгаа тогтвортой стандартыг боловсруулж, түүнийг малчид болон боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлэн тогтвортой ноолуурын ханган нийлүүлэлтийн сүлжээнд монголчууд голлох үүрэгтэй оролцох нөхцөл боломжийг бий болгоход оршиж буй.

ТННЭ-ийн баг хамт олны хичээнгүй зүтгэлийн үр дүнд өдгөө олон улсын болон дотоодын 100 гаруй брэнд, ноолуурын үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа компани гишүүнээр элсээд байна.

Британи дахь ажлын багт ноолуурын салбарын мэдлэг туршлагатай Англи, Америк, Шотланд хүмүүс ажилладаг. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлд “Burberry”, “Johnston of Elgin” зэрэг нэр хүндтэй брэнд үйлдвэрлэгчдийн төлөөлөл бий. Мөн олон улсын ан амьтныг хамгаалах Хатан хааны нийгэмлэг (RSPCA)-ийн салбартаа танигдсан судлаач эрдэмтдээс бүрддэг. Британийн хуульд заасны дагуу эвсэл маань үйл ажиллагаа болоод үр дүнгээ тайлагнаад явдаг тул бүх тайлан мэдээг www.gov.uk хуудаснаас цахим хэлбэрээр харах боломжтой.

Харин Монгол дахь салбар маань 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй. Ноолуурын эхний шатны үйлдвэрлэлийг малчид хийдэг учраас тогтвортой байх стандарт буюу байгаль орчин, ан амьтан болоод бэлчээртэй ээлтэй, малдаа халгаагүй байдлаар малаа маллаж, ноолуураа дараагийн шат дамжлагуудад хорогдол, зардал багатай самнах, зохистой дадлуудыг малчдад сургах, сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Одоогоор 15 аймгийн 57 сумын хоршоог сургалт, мэдээллээр хангаж, мал маллагаа болон бэлчээрийн зохистой тохирлын үнэлгээ хийсэн. 2020 оноос эхлэн боловсруулах үйлдвэрүүдэд чиглэсэн ноолуур боловсруулах зохистой дадлыг бий болгох сургалтуудыг явуулж ирлээ. Нэг ёсондоо өнгөрсөн зургаан жил тогтвортой стандартыг хангасан ноолуур бэлтгэн боловсруулах, улмаар зах зээлд гаргахад анхаарч ажилласан. Бидний монгол дахь үйл ажиллагааг www.sustainablefibre.mn цахим хуудаснаас харж болно.

2020-2021 онд туршилтын байдлаар ТННЭ-

ийн стандартыг хангасан ноолуурыг малчны хоршооноос эхлэн мөшгих тогтолцоог мөрдөн экспортод гаргасан. Тухайлбал, 2020 онд 100 тонн, 2021 онд 470 гаруй тонн ТННЭ-ийн стандартыг хангасан ноолуурыг барууны үйлдвэрлэгчдэд нийлүүлээ.

Зургаан жил хамтран ажилласны үр дүнд ТННЭ 2021 онд олон улсын тогтвортой ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүртгэдэг “ISEAL” олон улсын байгууллагад гишүүнээр элссэн. Эл олон улсын байгууллагад элссэн нь Монгол ноолуур барууны зах зээлд гарах гол шалгуурыг хангасан гэж ойлгож болно. Ингэснээр ТННЭ-ийн стандартаар баталгаажсан ноолуур чанарын шаардлага хангасан гэдгийг “ISEAL”-ийн гишүүн барууны брэндүүд хүлээн зөвшөөрч худалдан авах нөхцөл бүрдэж буй хэрэг.

-Цаашид ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ?

-Стратегитөлөвлөгөөг 2030 он хүртэл гаргасан. Илүү олон малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрүүдэд хүрч ажиллана. Зөвхөн өөрийн стандартыг хэвшүүлэхэд анхааран ажиллана. Мөн ирээдүйн залуу малчдаа бэлтгэх, малаа илүү үр ашигтайгаар сонгон үржүүлэх чадамжийг нэмэгдүүлэхэд гишүүн байгууллагуудынхаа дэмжлэгийг авч мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. ТННЭ-ийн гишүүн “Johnston of Elgin” компанийн санхүүжилтээр “Шинэ үеийн малчин” төслийг хэд хэдэн аймаг, сумдын сургуульд хэрэгжүүлдэг. АНУ-ын “JCrew” корпорацийн санаачилгаар 1000 малчин эмэгтэйг чадавхжуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Одоогоор Монгол дахь Британийн Элчин сайдын яамны санхүүжилтээр бог малын үржүүлэгтэй холбоотой малчдын мэдлэг, чадамжийг сайжруулах сургалтыг онлайнаар явуулж байна.

Малын тоонд бус чанарт анхаарах, сайн үүлдрийн ямаан сүргийг үржүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, шинэ цагийн малчны цахим технологийн мэдлэгт нь анхаарах зэрэг маш олон төрлийн сургалт, төслүүд хэрэгжүүлнэ.

ТННЭ-ийн стандарт нь “ISEAL”-аар хүлээн зөвшөөрөгдөж, зах зээлийн давуу байдлыг үүсгэж байгаа тул бусад орны ноолуурын салбарынхан ч мөн адил эл стандартыг мөрдөх хүсэл сонирхол нэмэгдэж байгаа гэдгийг ойлгож эхлээд буй. ▶

► Бид өнгөрсөн жилээс БНХАУ-тай хамтран, тэндхийн малчид, үйлдвэрүүдэд стандартаа танилцуулж, сургалт хийж эхэллээ. Цаашлаад Иран, Афганистан гээд ноолуурын ханган нийлүүлэлтийн сүлжээнд голлон оролцдог улс орнуудад стандартаа хэрэгжүүлнэ.

-Таны бодлоор Монголын ноолуурыг дэлхийд гаргахын тулд бид юунд анхаарах шаардлагатай вэ?

-ТННЭ үүсгэн байгуулагдаад удаагүй, зорьсноо хэрэгжүүлэхийн төлөө алдаа оноон дээрээ суралцаад урагшилж яваа, хилийн чанадад суугаа монголчуудын зүрх сэтгэлээс бий болсон байгууллага. Ноолуурын салбарт нөлөөгөө тогтоож, гадаадын үйлдвэрлэгчид, брэндүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг бий болгон эзэмшихийг хүсэгч олон улсын байгууллагууд цөөнгүй байдаг. Ямар азаар Британид суугаа хэсэг монголчууд эл орон зайг түрүүлж харан ноолуурын салбарын мэдлэг туршлагатай гадныхныг нэгтгэж, Монгол малчиддаа хүрч ажиллах боломжийг нээсэн юм гэж боддог. Монголчууд ноолуурын салбарт өөрсдийн орон зайгаа алдаж, бусдын тулгасан нөхцөлд хавчигдан ажилладаггүй байхын тулд дотроо ойлголтоо нэгтгэж, хамтран ажиллах нь чухал. Монголчууд нэгдмэл байр суурьтай байвал ямааг маань ирээд самнаж дөнгөхгүй гадныхан хаа холдох вэ.

Дотроо үл ойлголцол үүсвэл гадныхан тун овжин ашиглана гэдгийг л байнга санах хэрэгтэй. Аль ч салбарт тохиолдож болох, тохиолдож байгаа дүр зураг. Үүнд л анхаарах шаардлагатай.

-Та Их Британи дахь монголчуудын холбоог тэргүүлдэг. Энэ холбооныхоо талаар уншигчдад дэлгэрэнгүй ярьж өгнө үү?

-1999 онд энэ холбоо Амарбаясгалангийн санаачилгаар үүссэн. Тэр цагаас Британи дахь монголчууддаа чиглэсэн соёлын болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулж ирсэн. Сонирхлын бүлгүүдээрээ зохион байгуулалтад орж, өдгөө спорт, соёл, боловсролын чиглэлээр 10 гаруй олон нийтийн байгууллага Британид идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Монголчуудын үүсгэн байгуулсан бизнес ч цөөнгүй бий.

Британи дахь Монголчууд маань идэвх санаачилга ихтэй. Монголчуудаа гэсэн сэтгэлээр олон хандив, аяныг зохион байгуулж бусдыгаа



уриалдаг. Үүний нэг нь Ковид-19 цар тахлын үед хэсэг монголчууд санаачилга гаргаж ажилгүй болсон хүмүүстээ хүнсний бүтээгдэхүүн, талон тараасан. Энэ үйл ажиллагаа өргөжөөд Манчестерт үргэлжилж тэндхийн монголчууд тусламжийн аян өрнүүлсэн. Лондон, Манчестерт нийт 5000 гаруй фунтын хандив цугласан. Өнгөрсөн зун хүчилтөрөгчийн аппарат хандивлах аян өрнүүлэн 2000 гаруй фунт цуглуулж Монгол руу илгээж байлаа. Одоогоор аймаг бүрт 1000 англи хэлний ном, хичээлийн хэрэгсэл тараах аян зохион байгуулж байна. ■

Бүтээн байгуулалт

Эрчээ алдсан эрчим хүчийг сэргээх станц

Аливаа улсын эдийн засгийн тусгаар тогтнолын нэгэн чухал багана нь цахилгаан эрчим хүчний хангамж, бие даасан байдал юм. Гэтэл манай улс хөрш орнуудаас эрчим хүч импортлоход жил бүр дунджаар 400 гаруй тэрбум төгрөг зарцуулж байна. Тухайлбал, Оюу толгой төсөл жилд 120 сая ам.долларын эрчим хүчийг БНХАУ-ын Өвөрмонголын Өөртөө Засах Орны эрчим хүчний системээс худалдан авч буй. Тиймээс эрчим хүчний хангамжийг цаашид нэмэгдүүлэх, дотоодоосоо бүрэн хангадаг болохыг манай улс зорьж буй.

Нэн тэргүүнд Оюутолгой төслийн БНХАУ-аас худалдан авч байгаа эрчим хүчийг дотоодоосоо хангах нь эрчээ алдсан эрчим хүчийг сэргээхэд ихээхэн ач холбогдолтой юм. Энэ зорилтын хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станцыг барих төслийн ажил нэгэнт гараанаас гарчээ. Төслийн ТЭЗҮ-ийн дагуу бүтээн байгуулалтад нийт 808.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Энэ дүнд 450 МВт-ын дулааны цахилгаан станц, Тавантолгой-Оюутолгой, Тавантолгой-Тавантолгой дэд станц чиглэлийн 161 км цахилгаан дамжуулах агаарын шугам, станцын ус хангамжийн байгууламжийн өртгүүд багтаж байна.

Одоогоор цахилгаан станц барих төслийн бэлтгэл ажил 100 хувь хангагджээ. Тендерийн гүйцэтгэгчийг энэ оны II улиралд багтаан сонгон шалгаруулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд барилга угсралтын ажлыг III улиралд багтаан эхлүүлнэ гэж төслийг хэрэгжүүлэгч Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК мэдээлсэн.

Төслийн нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК санхүүжүүлнэ. Энэ хүрээнд төслийн 2022 онд шаардлагатай санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө тусгасан байна.



Үлдэгдэл 70 хувийн санхүүжилтийг тендерт оролцогч тал хариуцна. Тухайн санхүүжилтийн 30 хувийг өөрийн хөрөнгөөр, үлдэгдэл 70 хувийг банк, санхүүгийн байгууллагын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөж байна. Энэ хувилбараар төслийг санхүүжүүлбэл банк, санхүүгийн байгууллагын зээлийн эргэн төлөлтөд Засгийн газар баталгаа гаргах юм.

Уг мега төслийн явцын талаар “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Тэнгэртэй ярилцлаа.

Г.Тэнгэр: Бэлтгэл ажлыг 100 хувь хангаад байна



-Өнөөдрийн байдлаар төслийн явц хэдэн хувьтай байна вэ? “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК байгуулагдсанаас хойш ямар ажлууд хийгдэв?

-Компани 2020 онд байгуулагдсанаас хойш төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, батлуулаад байна. Станц барих газрыг сонгож, баталгаажуулан газрын гэрчилгээг авч, трассын дагуух газрыг Өмнөговь аймгийн Цогт-Цэций, Баян-Овоо, Ханбогд сумын газар зохион

► байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Үүгээр зогсохгүй, төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбох болон Оюутолгой уурхайг цахилгаан эрчим хүчээр хангах, ЦДАШ-ын ажлын иж бүрэн зураг төсөв, дулааны цахилгаан станцын тогтворжилтын горим, тооцоог хийж, дулааны цахилгаан станц болон ЦДАШ-ын байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэж, Байгаль орчны яамны мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан. Барилга угсралтын ажлын үед шаардагдах тусгай зөвшөөрлүүд болон техникийн нөхцөлүүдийг авах зэргээр бэлтгэл ажлыг 100 хувь хангаад байна.

Тавантолгой дулааны цахилгааны станцын нэгдүгээр блокийг 2024 оны II улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Энэхүү 450 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай цахилгаан станц нь сүүлийн үеийн дэвшилтэд технологи, байгаль орчинд сөрөг нөлөө багатай дахин халаагчтай конденсацийн турбин, агаарын хөргөлттэй конденсатор болон хаалттай хөргөх цамхагтай, жилд 2.8 тэрбум кВт.ц цахилгааныг эрчим хүчний системд нийлүүлнэ.

-Тендерийн ялагчийг тодруулах хугацаа яагаад удаа дараа хойшилж байна вэ? Шалтгаан нь юу вэ?

-Ковид-19 цар тахлын Омикрон хувилбар эрчимтэй тархсанаас олон улс хилээ хааж, хорио цээрийн дэглэмээ чангатгасан. Мөн “Бээжин-2022” өвлийн олимптой холбогдуулан БНХАУ дотоод, гадаадад зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоолоо. Эдгээр шалтгааны улмаас тендерийн баримт бичиг бэлтгэх, төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, хөрөнгө оруулагчтай яриа хэлэлцээ хийхэд хүндрэл үүсэж тендерг оролцогч компаниудаас тендер нээх хугацааг хойшлуулах хүсэлт удаа дараа ирүүлсэн. Үүнийг зайлшгүй хүндэтгэх шалтгаан гэж үзэж, тендерийг амжилттай зохион байгуулах үүднээс хугацааг нь хойшлуулах шийдвэрийг Эрчим хүчний яамнаас гаргасан.

-Тус төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгахад учирч болзошгүй гол саад (улс төр, эдийн засаг, бизнесийн гэх мэт) юу вэ?

-Томоохон мега төслийг хэрэгжүүлэх явцад олон эрсдэл учирч болзошгүй. Тухайлбал, төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засгийн төлөв байдлаас үүдэн өсөх, олон улсад болж буй зөрчилдөөн, цар тахлын тархалт

зэргээс үүдэн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, тээвэрлэлт саатах, барилга угсралтын ажлын хугацаа уртсах, төслийн санхүүжилтийн зээлийн хүү өндөр, хугацаа богино байх, гадаад валютын ханшийн зөрүү зэрэг олон эрсдэл бий. Эдгээр эрсдэлийг компани удирдах бөгөөд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг шилжүүлэх, даатгуулах, бууруулах арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажиллана. Нэн тэргүүнд төслийн санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх нь тулгамдаж буй асуудал болоод байна.

Төслийн үлдэгдэл 70 хувийн санхүүжилтийг ЕРС гэрээ байгуулагдсаны дараа банк, санхүүгийн байгууллагатай хэлэлцээр хийж тодорхой болгоно.

-Тавантолгой дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор манай улсын эдийн засагт үзүүлэх ач холбогдлын талаар товч мэдээлэл өгнө үү?

-Тавантолгой дулааны цахилгаан станц жилд 3.1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Энэ нь импортын цахилгаан эрчим хүчний үнээс 1-2 дахин бага өртөгтэй. Мөн Оюутолгой, Тавантолгой, Цагаан Суварга, Эрдэнэс Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах юм.

Станцын бүтээн байгуулалтын ажлын үед 2000 ажлын байр шинээр бий болж, станц ашиглалтад орсны дараа 250-300 байнгын ажлын байр бий болно. Үүний зэрэгцээ улсын болон орон нутгийн төсөвт жил бүр 34.5 сая ам.долларын татвар, хураамжийг төвлөрүүлнэ.

“Оюу толгой” ХХК-тай энэ оны нэгдүгээр сарын 26-ны өдөр байгуулсан цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд зааснаар эхний арван жилийн турш жил бүр хамгийн багадаа 1.3 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэх доод хэмжээг тогтоож, үүрэг хүлээлгэсэн. Үүний дүнд жил бүр гадагш чиглэж буй 120-140 сая ам.доллар, цаашлаад далд уурхай ашиглалтад орсноор энэ дүн дээр нэмэгдэх валютын гадагшлах урсгалыг дотооддоо үлдээх боломж бүрдэх юм.

Мөн коксжих нүүрсний олборлолтын үед хаягдаж буй бага илчлэгтэй эрчим хүчний нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулах нь төслийн нэг том давуу тал гэдгийг дурдах нь зүйтэй. ■

Тендерийн гүйцэтгэгчийг энэ оны II улиралд багтаан сонгон шалгаруулна.

Build Mongolia

Т.Баттулга: BUILD MONGOLIA-2022 бол бүтээн байгуулалтын салбаруудын хувьд нэг цэгийн төвлөрөл юм



Эдийн засгийн чухал салбаруудыг хамарсан “Build Mongolia” үзэсгэлэнгийн хоёр дахь дугаарыг өмнөхөөс илүү өргөн хүрээтэй, далайцтай зохион байгуулна.

“Build Mongolia 2022” олон улсын үзэсгэлэнгийн бэлтгэл ажлын талаар ерөнхий зохион байгуулагч “Экспо Монгол” компанийн ерөнхий захирал Т.Баттулгаас тодрууллаа.

-Цар тахлаас шалтгаалаад сүүлийн жилүүдэд олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнүүд цуцлагдаж, зарим нь хойшилсон. Энэ жил олон улсын чанартай хэд хэдэн үйл ажиллагаа болох юм байна. Үүний нэг нь “Build Mongolia-2022”. Уг үзэсгэлэнгийн бэлтгэл ажил хэдэн хувьтай яваа, хэчнээн компани, аж ахуйн нэгж оролцох талаар мэдээлэл өгнө үү?

-Одоо ч цар тахлын тухай ярианаас залхдаг боллоо шүү. Хоёр жил гаруй, гурав

дахь жилдээ амьдралын хэмнэл, хөгжлийн боломж алдагдлаа. Энэ хугацаанд ажил төрлөө хойшлуулсан бизнесийн байгууллагуудын дунд харилцагчидтайгаа нүүр тулан уулзах, хамтын ажиллагаагаа сэргээх, өсгөж өргөжүүлэх асар их хүлээлт ч бий боллоо.

Чухам ийм хүлээлтэд хариу болгож Монголын эдийн засгийн чухал салбаруудыг хамарсан “Build Mongolia” үзэсгэлэнгийн хоёр дахь дугаарыг өмнөхөөс илүү өргөн хүрээтэй, далайцтай зохион байгуулахаар бэлдэж байна. Үзэсгэлэн дөрөвдүгээр сарын 20-22-нд “Степпе Арена” буюу Мөсөн өргөөнд зохион байгуулагдана. Нийт 100 гаруй аж ахуйн нэгж оролцохоос одоогоор тэн хагас нь захиалгаа ►

► баталгаажуулаад байна.

-Барилга, уул уурхай, дэд бүтэц гээд маш том салбаруудыг хамарсан “Build Mongolia-2022” үзэсгэлэнгийн онцлог нь юу вэ?

-“Build Mongolia” буюу “Монгол бүтээн байгуулалт 2022” үзэсгэлэн бол бүтээн байгуулалтын бүх салбарыг хамарсан олон улсын үзэсгэлэн. Харилцан уялдаатай барилга, эрчим хүч, зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбаруудыг нэгэн дээвэр дор нэгтгэж, эдгээр салбарын шинэ бүтээгдэхүүн, шинэ технологийг танилцуулах зорилготойгоор зохион байгуулагдана. Манайд барилга, уул уурхайн үзэсгэлэнгүүд болдог боловч эрчим хүч, зам, хүнд үйлдвэрийн салбаруудын үзэсгэлэн тогтмол болдоггүй. Тэгэхээр энэ салбаруудын хувьд том боломж гэсэн үг. “Build Mongolia” бүтээн байгуулалтын салбаруудын хамгийн том, хамгийн далайцтай, хамгийн үр дүнтэй үзэсгэлэн байх болно.

-Үзэсгэлэнд оролцогчдод ямар давуу тал, боломжийг олгох вэ?

-Эдийн засгийн дээр дурдсан салбаруудын ажил өөр хоорондоо харилцан уялдаатай явагдаж, бие биенээ нөхөж байж бүтээн байгуулалт төгс хийгддэг. Тэдгээрт хэрэглэгддэг техник технологи, түүхий эд нэг учраас үзэсгэлэнд оролцож, бүтээгдэхүүнээ танилцуулах бизнесийн байгууллагуудын хувьд бүх зах зээл нь нэг дор цугларснаараа асар их давуу талтай. Жишээлбэл, хүнд машин механизм нийлүүлэгчдийн хувьд барилга, зам, уул уурхай, эрчим хүчний салбар бүгдээрээ зах зээл нь, цемент бетон хийц үйлдвэрлэгчдийн хувьд барилга, зам, эрчим хүчний салбар бүгдээрээ зах зээл, эрчим хүчний тоног төхөөрөмж нийлүүлэгчдийн хувьд эрчим хүчний салбар өөрөө, барилга, уул уурхай бүгдээрээ зах зээл болдог. Тийм учраас “Build Mongolia” үзэсгэлэн бол бүтээн байгуулалтын салбаруудын хувьд техник технологийн нэг цонхны үйлчилгээ, үзэсгэлэнд оролцогчдын хувьд зах зээлийн нэг цэгийн төвлөрөл юм даа.

-“Экспо Монгол” компаниас зохион байгуулж буй сүүлийн үеийн ажлуудаас сонирхуулахгүй юу?

-“Экспо Монгол” ХХК бизнес эдийн засгийн гол гол салбаруудад 2022 онд олон улсын агентуудтайгаа хамтран “Build Mongolia”,

“Mongolia Mining”, “Agro Expo”, “Auto Expo”, “Beauty Expo” гэсэн олон улсын чанартай таван үзэсгэлэн зохион байгуулна. Бид үзэсгэлэн зохион байгуулахад дэлхийн стандарт, орчин үеийн чиг хандлага, технологийн дэвшлийг нэвтрүүлж, бизнесийн байгууллагуудад үнэ цэнтэй маркетинг, худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэхийг зорьж ажилладаг.

-Олон улсын чанартай арга хэмжээ зохион байгуулахад хөрөнгө оруулалтаас эхлээд олон асуудал тулгамддаг байх. Үзэсгэлэн зохион байгуулахад ямар, ямар асуудал тулгамдаж байна вэ?

- Монгол улсад бизнесийн үзэсгэлэн зохион байгуулахад хамгийн бэрхшээлтэй асуудал бол зориулалтын танхимгүй байгаа явдал. Trade show буюу үзэсгэлэн бол бизнесийн аль ч салбарынхан худалдан авагчидтайгаа нүүр тулж уулзах, худалдан авагчийн хувьд технологитой өөрийн биеэр танилцаж, мэргэжлийн хүмүүсийн үгийг сонсож, зөвлөгөөг авах хамгийн чухал хамтын ажиллагааны орчин байдаг. Хот болгонд шахуу эрх биш нэг үзэсгэлэн зохион байгуулах зориулалтын танхим, худалдаа эдийн засгийн төв байдаг. Ихэвчлэн улсаас, эсвэл хотын захиргаанаас хөрөнгө оруулаад, түүнийгээ үзэсгэлэн зохион байгуулагчдад түрээслээд ажиллуулдаг.

Манайд сум болгонд жилд 1-2 удаа ашигладаг соёлын төв барьж, үр дүн муутай зүйлүүдэд хэдэн зуун тэрбумаар улсын төсвөөс хөрөнгө оруулдаг мөртлөө нийслэл хотдоо, бизнес эдийн засгийн төвдөө ганц зориулалтын үзэсгэлэнгийн танхим барьчихвал эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна гэж боддог.

-Энэ удаагийн үзэсгэлэнгийн ивээн тэтгэгчээр ямар компани ажиллаж байгаа вэ?

-Энэ удаагийн үзэсгэлэнгийн ерөнхий ивээн тэтгэгчээр ОХУ-ын алдартай Камазын машин механизмын албан ёсны дистрибьютер “Батсээр” компани, алтан ивээн тэтгэгчээр “Тоёота Сэйлс Монголиа” ХХК, мөнгөн ивээн тэтгэгчээр “Соёолон Интэрнэшнл” ХХК ажиллаж байна. Ивээн тэтгэгч, оролцогчдодоо талархал илэрхийлье. Та бүхний оролцоо, дэмжлэгээр бид бүхэнд хэрэгтэй бизнесийн хамтын ажиллагааны хамгийн таатай орчин бий болж байна. Монгол орноо хамтдаа бүтээн байгуулцгаая! ■

Үзэсгэлэнд оролцож, бүтээгдэхүүнээ танилцуулах бизнесийн байгууллагуудын хувьд бүх зах зээл нь нэг дор цугларснаараа асар их давуу талтай.

NOVEL

XCMG
HANWO XG90H 60TH

**АЖЛЫН
МАНГАС**

ХАМГИЙН БАГА

УРЬДЧИЛГАА: **8%**
ХҮҮ: **1.4%**



Speed Mate

СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ, ТОС ТОСОЛГООНЫ МАТЕРИАЛ



SHACMAN

ЧИРЭГЧ ТОЛГОЙ, ЧИРГҮҮЛ



MICHELIN



TRIANGLE



KUNLUN TYRE

**УУЛ УУРХАЙН
ХҮНД ДААЦЫН ДУГУЙ**

ХҮҮ 0%
ХҮҮГҮЙ ЛИЗИНГТЭЙ



NOVEL GROUP

7013-1616



Аз жаргал
түгээе!

Fomi бол хүндэлдэг авьяастнууд, алдартнууд,
олны танил эрхмүүдээр өөртөө болон хайртай
дотны хүмүүстээ мэндчилгээ дэвшүүлүүлэх
сошиал медиа платформ юм.



Download on the
App Store

GET IT ON
Google Play